



ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

2019.03.20, ЛХАГВА ~ №051 (1103)

~ СОЁЛТ ХҮНИЙ ӨГЛӨӨ СОНИН УНШИХААС ЭХЭЛДЭГ ~

ҮНЭ: 1000Т

Европын зах зээл дэх Монголын экспортын төрлийг өргөжүүлнэ

ХАА-н бүтээгдэхүүнээр экспортыг төрөлжүүлнэ.

> 4

Галын аюулгүй байдлын шалгалт дуусмагц гарсан түймэр

Шалгалт явуулснаас 12-хон хоногийн дараа нийслэлийн төр захиргааны байр нь шатлаа.

> 5

Boeing-ыг шалгах ажиллагаа хоёр дахь ослоос ч өмнө эхэлсэн байжээ

Boeing-ыг тангарагтны шүүхэд дуудахаар төлөвлөж байна.

> 9

FULL ENGLISH PAGE INSIDE

> 7

ОНЦЛОХ

УЛС ТӨР
Польш улс, АХБ, Европын сэргээн босголт хөгжлийн банкнаас зээл авахыг ЗГ-т зөвшөөрөв. **Үйлдвэрлэл, технологийн** паркийн эрх зүйн байдлын тухай хуулийг шинэчилнэ. **Сангийн сайд асан С.Баярцогт** мэдээлэл хийж, Т.Аюурсайхан гишүүнийг худал хэлж байна гэв. **Нотариатын тухай хуульд** нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл өргөн барилаа.

ЭДИЙН ЗАСАГ
Prophecy Development “Улаан овоо” ордоос дахин нүүрс олборлож эхэллээ. **Уул уурхайн нэгдэн, нийлэх** хэлцлийн дүн 2018 оны эцэст буурч, 10.9 тэрбум ам.долларт хүрэв. **“Анд энерги” 2019 онд** борлуулалтын орлогоо хоёр дахин өсгөхөөр төлөвлөжээ. **Топ 20 индекс 0.04 хувиар** өсөж, 20800.01 нэгжид хүрсэн байна.

Топ 20 индекс (нэгжээр)
30,000
25,000
20,000
15,000
10,000
20800.01



ТЭРБУМТАН ТӨРҮҮЛДЭГ ЗАХ ЗЭЭЛД МОНГОЛЧУУД “ӨЛГИЙ”-ТЭЙ БАЙНА

Монгол залуусын Nomadic Bear Games компани сүүлийн таван орчим жил тогтвортой үйл ажиллагаа явуулж байна. Өнгөрсөн онд дэлхийн зах зээлд хоёр ч бүтээгдэхүүнээ амжилттай нэвтрүүлсэн компанийн нэгэн тоглоомыг олон улсын хэрэглэгчид 12 сая удаа татжээ. ► 12

НИЙГЭМ
Нийгэмд өөрийн хувь нэмрээ оруулах хүсэл эрмэлзэлтэй залуучуудад зориулсан төвийг нэв. **2019 онд ОХУ-ын ЗГ-аас монгол** иргэдэд их, дээд сургуульд суралцах 500 эрх олгоно. **200 гаруй хүнд нүдний торлог** шилэнцрийн мэс заслыг эх орондоо амжилттай хийжээ. **Тусгай олимпын наадмаас** Монголын багийн хоёр дахь алтан медалийг Х.Балжинням авлаа.

ДЭЛХИЙ
Д.Трамп цалингаасаа 100 мянган ам.доллар Үндэсний аюулгүй байдлын яаманд шилжүүлэв. **Англи, Уэльс дэх 130 тэрбум** ам.долларын үл хөдлөх хөрөнгө оффшорт бүртгэлтэй. **Хятадад 5G сүлжээ ашиглан** 3000 километрийн алсаас тархины мэс засал амжилттай хийлээ. **Япон улс хүүхдэд бие мах** бодийн шийтгэл оноохыг хуулиар хориглохоор төлөвлөв.

УЛСТӨР
2018 онд зарласан тендерийн 70 хувь нь буцсан

Б.Сэлэнгэ
ЗГМ

Тендерийн асуудлыг цэгцлэх, төрийн худалдан авах ажиллагааг нэгтгэх зэрэг олон чухал асуудлыг тусгасан Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн өөрчлөлтийг өчигдөр хэлэлцэв.

Юун түрүүнд тендер зохион байгуулдаг тусгайлсан агентлагтай болохыг төсөлд тусгажээ. Мөн тендерийн шалгаруулалтад авлига, хээл хахууль, албан тушаалаа урвуулан ашиглах,

ашиг сонирхлын зөрчил үүсгэх боломжийг хязгаарласан чанаргүй бараа, ажил, үйлчилгээг дэмжих нөхцөлийг таслан зогсоохын тулд хуульд өөрчлөлт оруулахаар болсон. Үүний тод жишээ нь тендерт ялагдсан компани нь шүүхэд, төрийн худалдан авах ажиллагааг гацаадаг байдал нийтлэг үзэгдэл болсон явдал. Зөвхөн 2018 онд л гэхэд төрийн худалдан авах ажиллагааны 30 хувийн санхүүжилтийг олгож, үлдсэн 70 хувь нь буцаагдсан байна.

► 2

ЦАГ ҮЕ
Н.Ганболд: Онгоцны түрээсийг зогсоох эсэхийг ярилцаж байна

Г.Санжааханд
ЗГМ

11-ний өдөр түр хугацаагаар зогсоож, үйлдвэрлэгч компаниас зөвлөмж гаргасал “Boeing 737 Max”-ыг нислэгт ашиглахгүй байхаар шийдвэрлэсэн юм. Энэ талаар МИАТ-ын Үйлдвэрлэл эрхэлсэн тэргүүн дэд захирал Н.Ганболдтой ярилцлаа.

“Индонезид болсон “Boeing 737 MAX” онгоцны ослын дараа АНУ-д уг хэрэгт мөрдөн шалгах

ажиллагаа явуулж байсныг тус компани нуусан нь ил боллоо. Яг энэ үедээ танай компанид онгоцоо худалдсан байна. Одоо зээлийн төлбөр, бусад асуудлыг хэрхэн шийдэх вэ?
-Түрээсийн гэрээнд төлбөрийн зохицуулалтыг бүрэн оруулсан. Энэ онгоцыг түрээсэлж авсан компани нь “Avolon”.

► 5

ЦАГ АГААР

УЛААНБААТАР
2019.03.20

-3° | **-13°**

ҮҮЛ БАГАСНА

ЦАГ АГААРЫН ДЭГЭЭРЖИЙГ МЭДЭЭЛЛИЙГ 8 ДУГААР НҮҮРЭЭС УНШИНА УУ.

8 658 000 029 112 0 11 03

Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

НИЙТЛЭЛЧИЙН БУЛАН
Эрхэм генерал, офицерууд аа, энх цагт цэрэг яагаад эндээд байна вэ?

Г.Баярсайхан
@bayarsaikhanZGM

2013 оны аравдугаар сарын 6. Ховд аймагт байрлах зэвсэгт хүчний 123 дугаар ангийн байлдагч Д харуулынхаа цэг дээр сургуулийн сумаар өөрийгөө буудсан хэрэг гарав.

2015 оны 12 дугаар сарын 23. Налайх дүүргийн Городок тосгонд байрлах Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн нисдэг тэрэг осолдон нэг албан хаагч амиа алдаж, 10 хүн гэмтлээ.

2017 оны нэгдүгээр сарын 23. Зүүнбаянгийн 336 дугаар ангид

алба хааж байсан Б ээлжийн ахлагчдаа зодуулж, өвлийн шөнө гадаа нүцгэн зогссоны улмаас хөл нь хөлдөж, өсөн хуруугаа тайруулахад хүрэв.

2017 оны хоёрдугаар сарын 17. Зэвсэгт хүчний 186 дугаар ангид сургуулилтын гранат дэлбэрч, 19 настай байлдагч хоёр нүдээ хүндээр гэмтээж, зүүн гарынхаа гурван хурууг түллээ.

2017 оны дөрөвдүгээр сарын 11. Хээрийн сургалтын төв Тавантолгойд гранат дэлбэрч, хоёр цэрэг амиа алдаж, найман цэрэг шархдав.

► 3

САЙН МЭДЭЭ

AIC AZ
ACHIT IKHT LLC ACHIT ZES

Эрдэнэт үйлдвэрийн ил уурхайгаас гарсан балансын бус хүдрийн овоолгоос байгаль, цаг уурын нөлөөгөөр гарч байсан шимт уусмалыг “Ачит-Ихт” ХХК нь байгальд сөрөг нөлөө багатай аргаар боловсруулан үйлдвэрлэл явуулж байгаа бөгөөд тус ХХК нь саяхан Лондоны металл биржид бүртгэгдсэн Монголын анхны компани болсон.

“Ачит-Ихт” ХХК нь өөрийн болон Эрдэнэт үйлдвэрийн ажилчдад зориулан давуу эрхийн хувьцаа эзэмшүүлэхээр “Ачит Зэс” ХК-ийг байгуулан 2018 оны 9 дүгээр сард давуу эрхийн хувьцаагаа баталгаажуулан эзэмшүүлж, анхны ногдол ашгаа 2018 оны 12 дугаар сарын 15-нд тарааж байжээ.

Харин тус компани давуу эрхийн хувьцааны хоёр дахь

“Ачит-Ихт” ХХК давуу эрхийн хувьцааны 2 дахь улирлын ногдол ашгаа тараалаа

улирлын ногдол ашгаа энэ сарын 15-нд тараасан байна.

Үндэсний үйлдвэрлэгч “Ачит-Ихт” ХХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд олон ажил санаачлан хэрэгжүүлж байгаагаас дурдвал, хүүхэд, залуучууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, түүгээр зогсохгүй мэргэжлийн баг, тамирчид бэлтгэл сургуулилт хийх боломжтой мөсөн ордоны бүтээн байгуулалтын ажилд хувь нэмрээ оруулж байна.

АЛТ 1305.66 1.95%	ЗЭС 6425 0.09%	10-ЧИНГИС БОНД 98.700 0.13%	ХУРАЛДАЙ БОНД 110.70 0.12%	ГЭРЭГЭ БОНД 99.330 0.12%	АМ.ДОЛЛАР 2631.91	ЮАНЬ 391.82	РУБЛЬ 40.94
--------------------------------	-----------------------------	--	---	---------------------------------------	-----------------------------	-----------------------	-----------------------

Улс төр

2018 онд зарласан тендерийн 70 хувь нь буцсан

Яам, агентлагууд бодлого гаргах биш тендер зохион байгуулах ажилд ихэнх цагаа зарцуулдаг болсон учраас дээрх агентлагийг сэргээн ажиллуулахыг хүсч байгаа юм.



С.Батсайхан / ЗГМӨ

Тендер шалгаруулах тусгай агентлаг байгуулна

Тиймээс хэрэв тендер оролцсон компани маргаан үүсгэхээр бол тендерийн үнэлгээний нэг хувьтай тэнцэх хэмжээний баталгааны мөнгийг байршуулах зэрэг хариуцлагын асуудлыг нэмэлт, өөрчлөлтийн төсөлд тусгажээ. Гишүүдийн зүгээс уг хуулийн нэмэлт өөрчлөлтийн хүрээнд

Худалдан авах ажиллагааны газрыг эргэн сэргээх зайлшгүй шаардлага байгааг онцолж буй. Өөрөөр хэлбэл яам, агентлагууд бодлого гаргах биш тендер зохион байгуулах ажилд ихэнх цагаа зарцуулдаг болсон учраас дээрх агентлагийг сэргээн ажиллуулахыг хүсч байгаа юм. Түүнээс гадна хуульд дотоодын худалдан авалтыг тусгайлан дэмжих зохицуулалт бий. Үүнд нийт 155 барааг дотоодын үйлдвэрээс худалдаж авахаар тусгасан байна. Хэлэлцүүлгийн үеэр УИХ-ын гишүүн З.Нарантуяа тендертэй холбоотой маш

их гомдол байдаг. Тиймээс хуулийг өөрчлөх зарчмын хэд хэдэн асуудал бий. Тухайлбал, тендерийн даалгавар. Бид ихэвчлэн тендер оролцохоор ирүүлсэн материалыг шалгаруулах гэж зорьдог. Угтаа тендерийг ямар зорилгоор зарлаж байна, түүнд нийцсэн даалгавар өгөх хэрэгтэй. Гэтэл орон нутагт энэ асуудал хоцрогдоод байна. Ажил үйлчилгээний чанар, оновчтой байдал хэр дэвшил авчирсан хууль болж байгаа вэ хэмээв. Хоёрдугаарт, салбарын онцлогт тохирсон тендер зарлагдах. Үүн дээр тусгайлсан зохицуулалт орж

Тендерийн шалгаруулалтаар маргаан үүсгэж буй компани баталгаа байршуулна

байгаа эсэхийг тодруулсан юм. Сангийн яамны хууль эрх зүйн газрын дарга Н.Энхболд “Хуулийн төсөлд техникийн тодорхойлолттой холбогдуулан бараа, ажил үйлчилгээний стандартад

нийцсэн байх ерөнхий агуулгыг хуульд оруулсан. Харин нарийн зохицуулалтыг Засгийн газрын тогтоолоор зохицуулаад явах боломжтой. Нарийн мэргэжлийн мэдлэг шаардлагатай, тэр талаар сайн мэдэхгүй бол орон нутаг мэргэжлийн байгууллагаас зөвлөгөө авах нь нээлттэй. Харин уул уурхайн тоног төхөөрөмжийг худалдан авахтай холбоотой тусгайлсан зохицуулалт энэ хуульд тусгагдаагүй” гэв. Уг хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Төсвийн байнгын хорооны гишүүд дэмжсэн юм. [ЗГМ]

ЗГМ ТОВЧХОН

» **ТӨСӨЛ**
Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж Нотариатын тухай хуулийн төслийг УИХ-д өргөн барилаа. Уг төсөл зургаан зүйлтэй бөгөөд нотариатын үйл ажиллагаа эрхлэгч нь хуульчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн байх, улмаар хууль зүйн үргэлжилсэн сургалтад жил бүр хамрагдаж, тогтоосон багц цагийг хангаж байхыг тусгажээ. Мөн нотариатын үйлчилгээг нэмэгдсэн өртөг ногдох бараа, ажил үйлчилгээнд хамааруулсан зохицуулалтаас хасаж байгаа аж.

» **ТОМИЛОЛТ**
Аугаа эх орны дайны ялалтын 70 жилийн ойгоор Монголын ард түмнээс бэлэглэсэн Москва хотын Хүндэтгэлийн дэнж дэх “Ялалтад тэмүүлсэн морьд” хөшөөнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан ОХУ-д хийж буй ажлын айлчлалын үеэрээ цэцэг өргөж, хүндэтгэл үзүүлжээ. Хүндэтгэлийн арга хэмжээнд Монгол Улсаас ОХУ-д суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Б.Дэлгэрмаа болон албаны бусад хүмүүс оролцсон байна.

» **БҮЛЭГ**
УИХ-ын ээлжит бус чуулганаар хэлэлцэх найман асуудлын жагсаалтад томилгоотой холбоотой буюу Зэвсэгт хүчний жанжин штабын дарга, дэд даргын томилгоог хэлэлцэхээр төлөвлөсөн. Харин МАН-ын бүлэг тус томилгоотой холбоотой асуудлыг хэлэлцэж нэгдсэн байр сууринд хүрээгүй байна.

Засгийн газарт зээлийн эрх олгохыг дэмжлээ

Польш улс, Азийн хөгжлийн банк, Европын сэргээн босголт хөгжлийн банкнаас зээл авна

Монгол Улсын Засгийн газар гадаадын зарим улс, олон улсын байгууллагаас зээл авах эрхээ парламентаар батлуулахаар хэлэлцүүлж байна. Өчигдөр

холбогдох байнгын хорооны хуралдаанаар Польш улсаас авах нөхцөлт зээл, Азийн хөгжлийн банк, Европын сэргээн босголт хөгжлийн банкнаас авах зээлийн гэрээний төслүүдийг танилцуулав. Азийн хөгжлийн банктай 2017-2020 онд санхүү, хөдөө аж ахуй, боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуй зэрэг салбарт хамтран ажиллахаар болсон. Энэ хүрээнд 334 сая ам.долларыг Монголд хуваарилсан. Энэ санхүүжилтийг хүнсний ногоо,

хилийн үйлчилгээ, усалгаатай газар тариалан, бүс нутгийн зам, эдийн засгийн чөлөөт бүс зэрэг таван төсөлд оруулахаар болжээ. Харин Европын сэргээн босголт хөгжлийн банкнаас 300 сая ам.доллар хүртэл зээлийн санхүүжилтийг Монголд олгох аж. Нөхцөл нь 10-16 жилийн хугацаатай, эхний гурван жил зээлийн хүүгээс чөлөөлөх аж. Өнгөрсөн хугацаанд тус банк нийт 1.6 тэрбум еврогийн 99 төсөлд хөрөнгө оруулалт хийсэн. Энэ төслийн санхүүжилт

бүхэлдээ хувийн хэвшилд чиглэж байсан. Харин одоо авах зээлийг Дархан-Улаанбаатар чиглэлийн автозам барихад зарцуулна. Энэ зам дөрвөн эгнээтэй байх бөгөөд хоёр эгнээг нь Азийн хөгжлийн банк, үлдсэн хоёр эгнээг нь Европын сэргээн босголт хөгжлийн банкны зээлээр барих юм. Харин үлдэгдэл санхүүжилтийг нь юунд зарцуулах нь одоохондоо тодорхой бус ч дээрх хэмжээндээ тултал нь

буюу 300 сая ам.доллар хүртэл санхүүжилт авна гэж Сангийн сайд Ч.Хүрэлбаатар хэллээ. Харин Польшийн Засгийн газраас манайд олгох нөхцөлт зээл 50 сая еврогийнх юм. Жилийн 0.15 хувийн хүүтэй, 28 жилийн хугацаатай, эхний таван жил үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх зэрэг нөхцөлтэй үг зээлийг хөдөө аж ахуй, дэд бүтэц, боловсрол, байгаль орчныг хамгаалах, эрүүл мэндийн салбарт зарцуулахаар төлөвлөж байна. [ЗГМ]

ЭШЛЭЛ



Энэ тал дээр яривал олон зүйл бий. Улс төр суллагчид эрдэмтэн мэргэд улстөрчид янз бүрийн зүйл ярьдаг. Гэхдээ дийлэнх нь Монгол Улс ШХАБ-д элсэх хэрэггүй гэсэн байр суурьтай байна. Миний хувьд тэдэнтэй санал нэг байгаа. ШХАБ-д Монгол Улс хэзээ ч орсон боломжтой юм. Орчихвол хэзээ ч гарах боломжгүй. Тэгэхээр одоохондоо ШХАБ-д орох гэж яарахын хэрэггүй.
Нийслэлийн АН-ын дарга Д.Баттулга

ЗАСГИЙН ГАЗАР

Үйлдвэрлэл, технологийн паркийн зөвшөөрлүүд үр дүнгүй болжээ

Засгийн газраас санаачлан боловсруулсан Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар өргөн барилаа. Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийг УИХ 2009 онд баталсан. Хуулийг

баталснаас хойш Засгийн газраас таван хуулийн этгээдэд паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгожээ. Гэвч тэдгээрийн үйл ажиллагаа нь эхлэл төдий, хөрөнгө оруулалт татаж чадаагүй байна. Тиймээс хуульд өөрчлөлт оруулж паркийн үйл ажиллагаанд төрийн зүгээс бодлогын болон татвар, санхүүгийн дэмжлэг үзүүлэх хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх аж. [ЗГМ]



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Худалдаа, хөгжлийн банк (ХХБанк)-ны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2019 оны 4-р сарын 29-ний өдрийн 17.00 цагт, Монгол улс, Улаанбаатар-14210, Энхтайваны өргөн чөлөө-19 хаягт байрлах Худалдаа, хөгжлийн банкны хурлын танхимд болно.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал:

- ХХБанкны 2018 оны үйл ажиллагааны тайлан болон хөндлөнгийн аудиторроор баталгаажсан санхүүгийн тайлан;
- Бусад.

2019.03.18

"ЛИДЕР ЭКАУНТ АУДИТ" ХХК		
Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2-р хороо, Төмөрний гудамж - 8, 405 тоот Утас: +976 7011-4519		
ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН		
"ДҮГЭРЭГ ББСБ" ХХК-ИЙН УДИРДЛАГАД		
Дүгнэлт	2017.12.31	2018.12.31
Бид "ДҮГЭРЭГ ББСБ" ХХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Санхүүгийн байдлын тайлан, Орлогын дэлгэрэнгүй тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Иенгэн гүйцэтгэлийн тайлан болон нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд, бусад нэмэлт тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ. Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС), Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу илэрхийлэгдсэн байна.		
Дүгнэлтийн үндэслэл		
Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн. АОУС-д зөвхөн аудиторын хүлээх үүрэг, хариуцлага" гэсэн хэсэгт тусгаж харуулав. Бид аудитын ажлыг хамаралтай хараат бус байдлын болон ёс зүйн шаардлагуудыг бүрэн биелүүлж ажилласан. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дээрх дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохицтой үндэслэл болно гэж найдаж байна.		
Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага		
Эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС), Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан заавар журмын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох стандартад, хуульд нийцүүлэн боловсруулан тогтмол мөрдөж ажиллах нь байгууллагын удирдлагын үүрэг болно.		
Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг, хариуцлага		
Хийж гүйцэтгэсэн аудит дээрээ үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт гаргах нь бидний үүрэг. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэв. Эдгээр стандартауд нь санхүүгийн тайлангууд материаллаг алдаагүй эсэх талаар үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд аудитыг төлөвлөж, аудитын горимуудыг гүйцэтгэхийг биднээс шаарддаг.		
Эдгээр горимуудыг аудиторын шийдэлд суурилан сонгодог бөгөөд үндэслэл болно юмуу алдаанаас үлдэлтэй материаллаг буруу илэрхийлэл эрсдэлийн тооцоолол багтадаг.		
Мөн санхүүгийн тайлангуудыг бүхэлд нь үнэлэхээс гадна удирдлагын зүгээс хийсэн томоохон тооцоолуудын үндэслэлтэй байдал, хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын тохиромжтой үндэслэлтэй үнэлэх явдлыг бид аудитад багтаасан. Бидний гүйцэтгэсэн аудит нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохицтой аудитын нотолгоогоор хангагдсан гэж бид итгэж байна.		
Захирал	П.Шаравхорол	

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ		
"ДҮГЭРЭГ ББСБ" ХХК		
2018 оны 12 сарын 31-ээр дуусгавар болсон		
БАЛАНС	/Мянган төгрөг/	
Үзүүлэлт	2017.12.31	2018.12.31
Мөнгөн хөрөнгө	1,105,787,601.37	855,775,012.83
Зээл /Цэвэрээр/	1,080,662,500.00	1,022,540,000.00
Бусад авлага	588,669,345.14	383,136,180.85
Бусад хөрөнгө	349,528,200.00	266,696,300.00
Эргэлтийн хөрөнгийн дүн	3,124,647,646.51	2,558,147,493.48
Үндсэн хөрөнгө	402,855,011.08	622,877,885.38
Биет бус хөрөнгө	869,444.44	-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	403,724,455.52	822,877,885.38
Нийт хөрөнгийн дүн	3,528,372,102.03	3,381,025,378.86
Болоно хугацаат өр төлбөрийн дүн	46,386,589.90	9,337,284.89
Энгийн хувьцаа	1,900,000,000.00	1,900,000,000.00
Хуримтлагдсан ашиг /алдагдал/	1,581,985,512.13	1,471,688,093.87
Эзэмшигчдийн өмч дүн	3,481,985,512.13	3,371,688,093.87
Өр төлбөр ба Эзэмшигчдийн өмчийн дүн	3,528,372,102.03	3,381,025,378.76

ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН		
Үзүүлэлтүүд	2018.12.31	
Хүүгийн орлого	111,337,976.92	
Хүүгийн зардал	27,564,575.34	
Цэвэр хүүгийн орлого	83,773,401.58	
Хүүгийн бус орлого	31,581.46	
Арилжаа болон ханшийн тэгшитгэлийн зардал	4,337.97	
Боловсон хүчний холбогдолтой зардал	54,065,837.68	
Бусад зардал	105,099,741.43	
Цэвэр хүүгийн бус орлого зардалын дүн	(160,138,336.62)	
Боловсон үндэслэлтэй сан байгуулахаас өмнөх үйл ажиллагааны ашиг/алдагдал	(76,364,934.04)	
Боловсон үндэслэлтэй зардал	24,885,200.00	
Үндсэн үйл ажиллагааны ашиг/алдагдал	(101,250,134.04)	
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	30,871,325.02	
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	23,487,747.10	
Ердийн үйл ажиллагааны ашиг/алдагдал	(93,866,556.12)	
Татвар төлөхийн өмнөх ашиг/алдагдал	(93,866,556.12)	
Орлогын албан татварын зардал	16,430,862.14	
Цэвэр ашиг/алдагдал	(110,297,418.26)	

Нийтлэлчийн булан

Гадаад ажиллагааны гавьяаны ард дотоодод бугшсан бүхэн дарагдах ёсгүй

◀1
2017 оны зургадугаар сарын 13. Тавантолгойн цэргийн сургалтын төвд марш тактикийн тэмцээний үеэр нэг алба хаагч нас барав.

2017 оны наймдугаар сарын 4. Таван толгой дахь зэвсэгт хүчний сургалтын нэгдсэн төвөөс баруун зүгт 26 км-т хоёр иргэн тэсрэх зүйлд өртөж, нэг нь нас барав.

2017 оны наймдугаар сарын 27. Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагч, байлдагч Б, Е, С нар усанд осолдож амиа алдав.

2019 оны нэгдүгээр сарын 22. Зүүнбаян дахь 336 дугаар ангид



Монгол цэргүүд Африкийн их халуун, Афганистаны өндөр уул, Иракийн элсэн цөлд, дайны галын тэргүүн шугам дээр үүрэг гүйцэтгээд энх тунх эргэн ирж байна. Гэтэл энх цагт эх орондоо алба хааж буй цэрэг эрчүүд яагаад амь үрэгдэж, эндээд байна вэ.

С.Батсайхан / ЗГМӨ

Эрхэм генерал, офицерууд аа, энх цагт цэрэг яагаад эндээд байна вэ?

алба хааж байсан 19 настай байлдагч А амиа алдав.

2019 оны нэгдүгээр сарын 30. Увс аймгийн Баруунтуруунд цэргийн албанд татагдсан цэрэг харуулын байрнаасаа галт зэвсэгтэй оргож, хил даваад алга болсон гэх дуулиан дэгдлээ. Түүнийг Тувагийн нутаг дэвсгэрээс хоёрдугаар сарын 2-ны өдөр амиа алдсан байхад нь олов.

2019 оны гуравдугаар сарын 1. Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн алба хаагч, ахлах ахлагч Г элс ачиж явсан ангийнхаа машинд дайруулж амиа алдав.

Цэргийн баяр дуусав уу, үгүй юу ямар муухай юм бичээд эхлэв ээ гэж зарим нь бодож магадгүй. Үнэндээ эдгээр тохиолдлыг шүүн олж, эвлүүлэн бичих амаргүй байлаа. Уншихад сэтгэл өвтгөм хэрнээ маш урт жагсаалт байгаа биз. Харамсалтай нь, энэ бүхэн сүүлийн тавхан жилийн дотор Монгол Улсын зэвсэгт хүчний салбарт болжээ. Ялангуяа сүүлийн хоёр жилд амиа алдсан цэргийн тоо эрс нэмэгдсэнийг та анзаарч харсан байх. Тиймээс цэргийн баярын уур амьсгал намжаагүй байхад, энэ салбарын асуудал ид

яригдаж буй энэ үед Монголын батлан хамгаалах салбарт бодлого дутагдах болсныг, Зэвсэгт хүчний өнөөгийн ороо бусгаа байдлын тухай зориглон бичихээр шийдлээ.

Үнэнийг хэлэхэд өнөөдөр батлан хамгаалах салбар шиг нэр хүндтэй салбар Монголд үгүй. Гадаад харилцааны тал дээр ГХЯ-наас ч илүү үүрэг гүйцэтгэсэн гэхэд хэтрүүлэг болохгүй байх. Яагаад гэвэл НҮБ-ын энхийн ажиллагаанд монгол цэргүүд оролцож, үүргээ нэр төртэй биелүүлсээр 20 шахам жилийн ардаа орхив. Чухам энэ ажиллагааны ачаар монгол цэрэг ямар тэсвэр тэвчээртэй, ямар ур чадвартай болохыг дэлхий дахинд мэддэг боллоо. Цэнхэр дуулгатнууд бол Монголын нэрийг дэлхий дахинд ээргээр харуулж буй цөөн тохиолдлын нэг. Эрэлхэг зоригтой эдгээр дайчдаар монгол хүн бүр бахархаж байна.

Гэхдээ гадаад ажиллагаанд гарсан гавьяаны ард дотоодод бугшаад буй муу муухай бүхэн дарагдаж үлдэх ёсгүй. Энэ салбарт эрдэнэт хүний амь үрэгдэх нь

энгийн үзэгдэл боллоо. Монгол цэргүүд Африкийн их халуун, Афганистаны өндөр уул, Иракийн элсэн цөлд, дайны галын тэргүүн шугам дээр үүрэг гүйцэтгэж байхдаа ч ингэж эрсдээгүй юм. Гэтэл эх орондоо алба хааж буй цэргүүд яагаад амь үрэгдэж, эндээд байна вэ.

Хамгийн сүүлд Зүүнбаянгийн цэргийн ангид алба хааж байсан байлдагч даргадаа дэглүүлж, амиа алдлаа. Гэтэл шүүх эмнэлгийн дүгнэлтэд өвчний улмаас нас барсан гэж гарчээ. Үүнд бухимдсан ар гэрийнхэн нь БХЯ-ны гадаа суулт зарлаж байна. Хүүгээ эр цэрэгт мorduулсны дараа цогцсыг нь хүлээн авч, тэдэн шиг шаналан суугаа олон ээж, аав бий. Харин алдаа гаргасан албан тушаалтнуудад бүгдэд нь хариуцлага тооцсон бил үү. Салбар хариуцаж буй сайд, дарга нар нь ямар арга хэмжээ авав. Ард түмнээсээ байг гэхэд ар гэрийнхэнээ нь уучлалт гуйв уу. Харамсалтай нь дарга нар нь хариуцлага ярихын оронд нуун дарагдуулж, чимээгүй өнгөрөөхийг илүүд үзсээр ирлээ. Амиа алдсан цэргүүдийг өвчний

шалтгаанаар гэж хэдий болтол аргаах юм бэ. Булавч бултайна, даравч далдайна гэгчээр эхнээсээ нуун дарагдуулсан хэргүүд чинь дараа дараагийн осол эндэгдлийн үндэс болсоор байгааг ухаарч байна уу.

Монгол цэргүүд галын тэргүүн шугам дээр үүрэг гүйцэтгэж байхдаа ч ингэж эрсдээгүй

Үнэнийг хэлэхэд энэ салбарт болохгүй юм асар их байна. Батлан хамгаалахын сайд асан Б.Бат-Эрдэнийн үед цэрэг амиа алдсан хэрэг гарахад “Би төрийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлдэг хүн. Осол эндэгдэл гарсан асуудлыг салбарын сайд биш, ЗХЖШ-ын дарга мэднэ” гэх агуулгатай юм ярьж, асуудлыг өөрөөсөө холдуулахыг хичээж байв. Тэгвэл бүхнийг мэддэг, асар

их эрх мэдэлтэй гэх ЗХЖШ-ын даргын суудал эзгүйрээд бараг хагас жил боллоо. УИХ-ын эрхэм түшээд орны хүнийг нь томилохын оронд сандал суудлын хэрүүл хийсээр хайран цаг хугацааг алдаж байна. Тэгэхээр цэргүүд амь насаа алдсан хэргийн хариуцлагыг хүлээх хүн байхгүй байна гэсэн үг мөн үү!

Уг нь батлан хамгаалах салбар бол улс орны аюулгүй байдлыг хангадаг, шаардлага гарвал зэвсэг хэрэглэдэг онцгой салбар. Тэдний өөрсдийнх нь ярьдгаар байнга дайны цагийн байдалтай үүрэг гүйцэтгэдэг. Ийм онцгой салбар учраас сахилга, хариуцлагын асуудлыг маш нухацтай авч үзэх ёстой. Гэтэл манайд яг эсрэгээрээ,

хамгийн хариуцлагагүй салбар нь батлан хамгаалах болоо юу даа. Энэ салбараас муу муухай бүхэн сонсогдох болоод удлаа. Генерал, дээд офицерууд нь нисэх онгоцоо, тэр бүү хэл танкаа хүртэл гаднынханд худалдсан тохиолдол гарч, хууль хяналтын байгууллагаар шалгуулж байв. Тэр ч бүү хэл салбар хариуцаж байсан сайд нь армийн хэрэглээний аяга, халбаганы

тендэрт оролцсон асуудал хүртэл гарч байсан удаатай.

Үнэхээр энэ салбарт болж бүтэхгүй зүйл дэндүү их байгаа учраас цэргийн баяраар хундага тулгаж, нэгнийгээ шагнаад өнгөрөөх биш, алдаа дутагдлаа ярилцаж, гарц шийдэл эрэлхийлэх ёстой. Монгол залуус цэрэгт татагдаад амиа алдах биш, эр цэргийн албанд яваад давхар мэргэжил эзэмшиж яагаад болохгүй гэж. Алба хаах хугацаандаа улс орны бүтээн байгуулалтад оролцож, мэргэжил эзэмшиж, цалин хөлс авах боломжийг нь хангаад өгч болохгүй гэж үү.

Гэтэл монгол цэрэг эрс энх цагт амиа алдсаар байгаа нь юутай эмгэнэлтэй. Нуун хааж, асуудлыг өөрсдөөсөө холдуулах тусам бугласан идээ бээр улам томрох вий. Онцгой салбар нэрийн дор бүхий л булхайтай асуудлаа дарж, далдалж өнгөрөөдөг байж болохгүй. Батлан хамгаалах салбар миний, бидний бодлоор Монгол Улсын нүүр царай, бусад бүх салбарт бүхий л талаараа сайны үлгэр жишээ болдог байх ёстой гэж үздэг юм. [ЗГМ]

С.ЦОГТБЯАР СУРЖ БАЙНА



Мөнгөний урсгал

ХАА-н бүтээгдэхүүнээр экспортыг төрөлжүүлнэ

Э.Сувд
Forbes Mongolia

Монгол Улстай 1989 оны наймдугаар сарын 1-ний өдөр дипломат харилцаа тогтоосон Европын холбоо 2017 оны арваннэгдүгээр сарын 2-ны өдрөөс Улаанбаатарт Төлөөлөгчийн газраа нээн ажиллуулж байв. Харин өнгөрсөн оны тавдугаар сарын 29-нд ноён Траян Лауренциу Христена Монгол Улсын Ерөнхийлөгчид Итгэмжлэх жуурах бичгээ өргөн барьснаар Европын холбооноос Монгол Улсад суух анхны Элчин сайд болсон юм. Түүнтэй ярилцлаа.



Ганц өөрчлөгдөөгүй зүйл бол монгол хүний зочломтгой, өгөөмөр зан. Үүнийг мэдээд би их баярласан

бүтээн байгуулалтын хүрээнд их зүйл өөрчлөгджээ. Харин миний харсан хамгийн сэтгэл хөдлөм өөрчлөлт бол залуу үеийнхний хүсэл тэмүүлэл, сонирхол юм. Тэд дотоодын нийгэм, эдийн засгийн саад бэрхшээлийг даван туулах, дасан зохицох чадвар, гадаад хэл эзэмшсэн байна. Зөвхөн Монголд гэлтгүй, олон улсын түвшинд өөрийгөө авч явах өндөр чадвартай болжээ. Мөн мэдээж автомашин, барилга байгууламжийн тоо нэмэгдсэн байна. Оюутан ахуй үедээ амьдарч байсан дотуур байраа олох гэж нэлээд буцсан шүү. Ганц өөрчлөгдөөгүй зүйл нь монгол хүний зочломтгой, өгөөмөр зан. Үүнийг мэдээд би их баярласан.

-Та Монголд ирэхээс өмнө ажилласан улстай харьцуулбал энд ажиллахад ямар ялгаа анзаарагдаж байна вэ?

-Би Армени, Казахстан Европын холбооны Төлөөлөгчийн газрын тэргүүнээр, мөн өөр бусад улсад ч дипломатчаар ажиллаж байсан. Армени, Казахстан, Монгол гурваас сүүдтэй ялгаа олж хэлэх хэцүү. Улс бүхэн өөрийн гэсэн онцлогтой шүү дээ. Армени, Казахстан хуримтлуулсан туршлагаасаа заримыг нь Монголд нэвтрүүлэх боломжтой гэж би үзэж байна. Учир нь бизнес, хөрөнгө оруулалт, хууль эрхзүйн орчин, боловсролын тогтолцоо зэрэг нь ерөнхийдөө төстэй санагдсан. Миний төрөлх улс Румынд болж өнгөрсөн өөрчлөлт надад туршлага, басхүү сургаж болсон. Мэдээж харьцуулах албагүй ч, бусдын алдаанаас сургаж авч, давтахаас сэргийлэх нь зарим үед хэрэгтэй байдаг шүү дээ. Өөрчлөлт шинэчлэлийн үед туулж өнгөрүүлэх үе шатууд бусад оронд давтагдах нь бий. Манай улс өөрчлөлт, шинэчлэлийг туулахдаа олон алдаа гаргасан. Би хамтрагчидтайгаа хэлэлцэх үедээ энэ туршлагаасаа хуваалцдаг. Монголд өөрийн туршлагаа нэвтрүүлэхэд хүмүүс нээлттэй хүлээж авч байна. Олон улсын стандартад нийцсэн зөв хууль тогтоомжтой байна гэдэг хамгийн сайн хэрэг. Гэвч хууль тогтоомж зөвхөн цаасан дээр бичигдсэн үгс төдий бол хэнд ч хэрэггүй. Хууль тогтоомж нь ард түмний өдөр тутмын амьдралд хэрэгждэг, үр дүнгээ өгдөг тогтолцоо хэрэгтэй.

-Бидний урилгыг хүлээн авч ярилцсанд баярлалаа.

Европын зах зээл дэх Монголын экспортын төрлийг өргөжүүлнэ

-Манай улсад ажиллах хугацаандаа ямар ажлуудыг хийхээр төвлөвсөн бэ?

-Монгол Улс, Европын холбоо хоорондын түншлэл, хамтын ажиллагааны хэлэлцээр 2017 оноос хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. Монгол Улстай байгуулсан хоёр талын харилцаа 30 жилийн хугацаанд хангалттай бэхжсэн гэж бодож байна. Тиймээс цаашид энэ харилцааг хөгжлийн дараагийн шатанд аваачих нь зүйтэй. Онц ач холбогдолтой энэхүү зорилтын хүрээнд олон ажил хийхээр төвлөж байна. Зөвхөн миний бүрэн эрхийн хугацаагаар хязгаарлагдахгүй, дараа нь томилогдох элчин сайдуудын бүрэн эрхийн хугацаанд ч энэ ажил үргэлжлэх учиртай.

-Европын холбооноос ямар газруудтай хамтран ажиллаж байгаа вэ?

-Өндөр ач холбогдол бүхий хариуцлагатай ажлыг хэрэгжүүлэхдээ олон газартай хамтарч

байгаадаа баяртай байна. Тухайлбал, бид Засгийн газар, иргэний нийгмийн байгууллагууд, төрийн бус байгууллагууд, мөн төслийг хэрэгжүүлэхэд оролцогч бүхий л талын агентлагууд болон энгийн ард иргэдтэй ч хамтран ажиллах юм. Энэ улсад явуулж буй бидний үйл ажиллагааны эцсийн үр дүнд ард иргэд хүртэх учиртай.

-Европын холбооны зүгээс хамтын ажиллагаагаа ямар салбарт илүүтэй төвлөрүүлж байгаа вэ?

-Нэн тэргүүнд анхаарах шаардлагатай, чухал ач холбогдолтой зорилтууд бий. Бид бүх салбарт гар бие оролцоод байж чадахгүй ч Монгол дахь түншүүдийн хамт ардчилал, хүний эрх, эдийн засгийн тогтвортой хөгжил, эдийн засгийг (уул уурхайгаас гадна) төрөлжүүлэх, мөн өөрчлөлт, шинэчлэлд дасан зохицох уян хатан байдлыг нэмэгдүүлэх, Тогтвортой хөгжлийн зорилтыг олон улсын түвшинд хэрэгжүүлэх зэрэг ажлын хүрээнд Монгол Улс

болон Европын холбоо дундын баримталдаг норм, стандарт, үнэлгээг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулахыг зорьж байна.

Энэ улсад явуулж буй бидний үйл ажиллагааны үр дүнг иргэд хүртэх учиртай

-Ойрын хугацаанд төвлөж буй ажлынхаа талаар бидэнтэй хуваалцаагүй юу?

-Ойрын хугацаанд бид Монгол Улсад аль хэдийн хэрэгжүүлээд эхэлсэн төслүүдээ эрчимжүүлж, ирэх жил Монгол Улс, Европын холбооны хооронд дипломат харилцаа тогтоосны 30 жилийн ойг бодит амжилтаар дүүрэн угтахыг зорьж байна. Мөн

Монголын экспортыг Европын холбооны зах зээлд нэвтрүүлэхэд туслах ажилд төвлөрч байна. Уламжлал болсон экспортын бүтээгдэхүүний нэр төрлийг илүү өргөжүүлэх зорилготой. Европын зах зээл стандарт, чанарын өндөр шаардлага тавьдаг учир одоогийн байдлаар бараа, бүтээгдэхүүн экспортолоход хүндрэлтэй байна. Тиймээс бид хөдөө аж ахуй, тодруулбал, ноос, ноолуур, арьс ширний салбар зэрэг нэмүү өртгийн сүлжээний болон бусад төслөөр дамжуулан Монголын эдийн засгийг төрөлжүүлж, бүтээгдэхүүнийг нь Европын холбооны зах зээлд нэвтрүүлэхийг хүсэж байна. Монголын экспорт Европын холбооны зах зээлд өчүүхэн бага хувь эзэлдэг учир үүнийг нэмэгдүүлэх шаардлагатай.

-Тогтвортой хөгжлийн хүрээнд ямар арга хэмжээ авах вэ?

-Өөрчлөлт шинэчлэлд дасан зохицох уян хатан байдлыг дээшлүүлэхэд бид холбогдох

газруудтай нь хамтран ажиллаж байна. Үүнийг Засаглалын хөтөлбөр гэж нэрлэдэг. Бид төрийн санхүүгийн менежментийн шинэчлэлд голлон анхаарах болно. Мөн мэдээж уул уурхайгаас бусад салбарт ажлын байр нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх болно. Энэ нь эдийн засгийг төрөлжүүлэхэд нэмэр болох юм. Бид Европын хөрөнгө оруулалтын банк, Азийн хөгжлийн банктай хамтран цэвэр ус дамжуулах, бохир ус зайлуулах төслүүдийг хэрэгжүүлж байна. Байгаль орчин, цаг агаарын өөрчлөлттэй холбоотой бүх арга хэмжээнд бид ажил үүргийнхээ дагуу дэмжлэг үзүүлнэ.

-Та Монголд боловсрол эзэмшсэн юм билээ. Таныг анх ирсэн үеэс хойш манай улс хэрхэн өөрчлөгдсөн байна вэ.

-Би Монголд анх 1990 онд ирж, 1995 онд МУИС-ийг төгсөж байлаа. Монголд их зүйл өөрчлөгдсөнийг харж байна. Ялангуяа дэд бүтэц, хотын

[ЗГМ СОНИН]

"Засгийн газрын мэдээ" сонин нь ардчилсан, шударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэм хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилго болгоно.

ТУЗ-ийн дарга
Эрдэнэбаатар ДОЛГИОН

Ерөнхий эрхлэгч
Батарын ДУЛАМХОРЛОО

Зөвлөх
Шатарбалын ДАВААДОРЖ

Орлогч эрхлэгч
Лхагважавын СУГАРМАА
Утас: 99903584

РЕДАКЦ

Улс төр, нийгэм, эрэн сурвалжаах мэдээллийн алба
Эдитор Б.Энхжаргал
Утас: 99901621

Цахим контент, бүтээгдэхүүнд зориулсан алба
Эдитор Г.Баярсайхан
Утас: 99903574

Эдийн засаг, уул уурхайн мэдээллийн алба
Эдитор З.Цэлмэг
Утас: 99901526

ЗАР СУРТАЛЧИЛГАА

Утас: 99903581
99903578
99907843

ХАЯГ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1 хороо, Энхтайвны өргөн чөлөө,
"Бло Скай тауэр" 407 тоот
Улсын бүртгэлийн дугаар: 1024
Утас: 70103131,
Факс: 7010606

ЦАХИМ ХУВИЛБАР

zgm.mn
ubinfo.mn
Дугаарын удирдагч
Э.Батцэцэг

Forbes Mongolia

ТА ЯГ ОДОО ЗАХИАЛ УТАС: 77074646

ТАНСАГ ХЭРЭГЛЭЭ Хэтийдсэн худалдан авалтууд

"Forbes 400" жагсаалтын гишүүд өнгөрсөн жил ямар эд хөрөнгөд гайхмаар их мөнгө зарцуулсан бол? Мэргэжлийн спортын баг, түүхэн дурсгалт ном, их хотын зурагт хуудас, эдгүүтэй хөөрхөн амьтан гэхчлэн олныг нэрлэж болно. Эдгээрээс жишээ болгон танилцуулъя.



ЖЕФРИ ХИЛЬДЕБРАНД ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, HILCORP ENERGY \$300,000

Худалдан авалт: Houston Livestock Show and Rodeo үзэсгэлэн худалдааны үеэр аварга цол хүртсэн хонийг түүхэн дэх хамгийн өндөр үнээр авав. Тус орлогын дийлэнхийг шоуны залуу оролцогчдод тэтгэлэг болгон гардуулсан.

ЛЕН БЛАВАТНИК ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ \$90 САЯ

Худалдан авалт: Манхэттений Аппер Ист-Сайд хороолол, Ист-64 дүгээр гурамжны 19 тоот таван давхар байр. Үүнийг ердөө 10 сарын өмнө 79.5 сая ам.доллараар худалдсан байсан.



Los Angeles Times

HURRICANE MARIA | ONE YEAR LATER

GOP pushes Kavanaugh accuser to testify

ПАТРИК СУН-ШИОНГ БИОТЕХНОЛОГИ \$500 САЯ

Худалдан авалт: Худал мэдээ биш шүү. Доктор тэрбумтан Los Angeles Times, San Diego Union-Tribune сонин болон Калифорни мужийн орон нутгийн хэд хэдэн хэвлэлийг худалдаж авснаар сэтгүүл зүйн гал тогоонд нэгдлээ.



ДЭВИД ТЕППЕР ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, APPALOOSA MANAGEMENT \$2.3 ТЭРБУМ

Худалдан авалт: "NFL"-ийн "Carolina Panthers" багийг спортын түүхэн дэх хамгийн өндөр үнээр авсан. Худалдан авалтад өмнөх эзэмшигч Жерри

Ричардсоны хөшөө багтсан бөгөөд үүнийг гэрээ ёсоор Шарлот хот дахь тус багийн цэнгэлдэх хүрээлэнгийн дэргэд хэвэр үлдээх ажээ.

TIME THE OPTIMISTS

МАРК БЕНИОФФ ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ, SALESFORCE \$190 САЯ

Худалдан авалт: "Time" сэтгүүл. "Newsweek"-ийг 2010 онд нэг ам.доллараар (10 сая ам.долларын өртэй байсан) худалдсантай харьцуулахад хэвлэмэл сэтгүүлд бараг 200 сая ам.доллар төлнө гэдэг зах зээл сэргэснийг илтгэж байна.



Цаг үе

Н.Ганболд: Онгоцны түрээсийг зогсоох эсэхийг ярилцаж байна

Гэрээг нэг талаас шууд цуцлах эрх байхгүй

«1 Энэхүү компанитай бид и-мэйлээр холбогдож, онгоцны түрээсийг зогсоох эсэх асуудлаар ярилцаж байна. Түрээсийн гэрээнд манай тал төлбөр тооцоогоо тасралтгүй төлөх үүрэгтэй ч, энэ онцгой тохиолдолд Avolon компанийн төлөөлөлтэй уулзаж, цаашдын нөхцөлийн талаар тохиролцоонд хүрэх шаардлагатай болсон. Тиймээс энэ сарын 28-нд цаг тохирсон, эцсийн шийдвэр гараагүй байна. Бидний тооцоолсноор “Boeing 737 MAX” онгоц ирэх сарын 15 хүртэл нислэгт гарахгүй. Тэгэхээр нэг сарын түрээсийн төлбөрийг төлөх эсэх асуудлыг Avolon, эсвэл “Boeing” компанитай уулзсаны эцэст тодорхой болох юм.

«Дэлхийн 70 гаруй орон тус онгоцноос татгалзсан. Тухайлбал, Канад улс төлбөрөө буцааж авахыг шаардахаас гадна хохирлын нөхөн төлбөр шаардаж байна. Харин МИАТ компани яах гэж байна?»

«Энэ асуудалд эцсийн хариулт хэлэхэд эрт байна. Онгоц худалдах, түрээслэх бодлогын баримт бичигт хориос дээш жилийн насалттай онгоц ашиглахгүй гэж заасан байдаг юм. Өнөөдрийн байдлаар манайд 2000 оны хоёр ширхэг онгоц нислэг үйлдэж байна. Энэ оныг дуусгаад буюу ирэх оны тав, арванхоёрдугаар саруудад онгоцуудыг буцаах юм.

«Одоо авах гэж байгаа онгоц бол ашиглалт нь дууссан дээрх онгоцыг орлоно гэсэн үг. Анх 2011 онд “Boeing” компанитай байгуулсан гэрээгээр 2016 онд гурван онгоц худалдаж авах байсныг 2019 он болгож



С.Батсайхан / ЗГМӨ

хойшлуулсан. Эхний онгоц нь хоёрдугаар сард ирсэн. Төлбөрийн асуудал өмнөх онгоцуудыг ашиглаж байсан жишгээр явах ёстой. Гэвч одоогоор үүнийг түрээсийн компани төдийгүй “Boeing”-той

ярьж шийдвэрлэх шаардлагатай болоод байна.

«Сард хэдэн төгрөг түрээсэнд төлдөг юм бэ?»

«Одоогоор түрээсийн төлбөрийн асуудлаар компани хооронд хэлцэл өрнөж байгаа

Анх 2011 онд “Boeing” компанитай байгуулсан гэрээгээр 2016 онд гурван онгоц худалдаж авах байсныг 2019 он болгож хойшлуулсан. Эхний онгоц нь хоёрдугаар сард ирсэн.

«Дөрөвдүгээр сард багтаад асуудлаа шийдэх байх. Нэмэлт нислэгүүд долдугаар сараас эхэлдэг юм. Зуны нислэгээс өмнө асуудал шийдэгдэх байх гэж найдаж байна.

«Төлөвлөгөөний дагуу ажиллаж чадна гэсэн үг үү?»

«Ойрын 2-3 сардаа бол нислэгт онгоц дутагдах асуудал гарахгүй. Манай зургаан онгоц хангалттай. Нэг онгоцныхоо ашиглалтыг л нэмэгдүүлнэ гэсэн үг.

«Хоёр дахь онгоцоо авахаа хойшлуулсан гэх мэдээлэл гарсан байсан. Энэ үнэн үү?»

«Хойшлуулах талаар яриа явж байгаа. Эцсийн шийдвэр гараагүй. Дээр хэлсэн уулзалтад бид энэ саналаа тавина. Гэрээг нэг тал дангаар цуцлах эрхгүй. Онгоцоо авахын өмнө бид барьцаа байршуулдаг. Хоёр тал гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу зохицож шийдвэр гаргах байх.

“Boeing 737 MAX” онгоц ирэх сарын 15 хүртэл нислэгт гарахгүй

«“Boeing 737 MAX” онгоцыг ямар чиглэлүүдэд ашиглаж байсан бэ. Онгоц зогсоноор ямар эрсдэл бий болж байна вэ?»

«Бангкок, Европын чиглэл болон Хонгконгийн чиглэлд түлхүү ашиглаж байсан. Одоогийн байдлаар манай компанийн өвлийн улирлын ашиглалт явж байгаа учраас нислэгийн тоо тийм шахуу биш. Тиймээс бусад онгоцуудаараа нислэгийн үйл ажиллагааг хэвийн явуулах боломж бүрэн байгаа. [ЗГМ]

ЗГМ ТОВЧХОН

» СУРГАЛТ

Вакцин дархлаажуулалтын “Глобал Альянс” сангийн санхүүжилтээр ЭМЯ, НЭМГ, ХӨСҮТ-өөс хамтран халдварт саагийн эсрэг идэвхгүйжүүлсэн вакциныг дархлаажуулалтад нэвтрүүлэх бэлтгэл ажлын сургалтыг дүүрэг бүрт зохион байгуулж эхэллээ.

» ӨДӨРЛӨГ

НЗТГ, Монголын Хуульчдын холбоотой хамтран өнөөдөр иргэдэд үнэ төлбөргүй хууль, эрх зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх өдөрлөгийг зохион байгуулна. Тус өдөрлөг 09.00-17.00 цагийн хооронд Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвийн “Дүнжингарав”, “Мишээл”, “Драгон”, зургаан буудлын “Оргил” салбаруудад болно.

» ГЭМТ ХЭРЭГ

Нийслэлийн хэмжээнд цэргийн баяраар 324 хүн эрүүлжүүлэх байранд саатуулагджээ. Энэ нь өнгөрсөн онтой харьцуулахад өссөн үзүүлэлт аж.

» ОСОЛ

Энэ сарын 17-ны өдөр Хөвсгөл нууранд автомашинтайгаа цөмөрсөн иргэнийг Онцгой байдлын аврагчид маргааш өдөр нь эсэн мэнд гарган авч, амь насыг нь авран хамгаалсан байна. Нууранд автомашинтайгаа цөмөрсөн иргэн О нь согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож ийнхүү осолджээ.

» ЭРҮҮЛ МЭНД

Улсын нэгдүгээр төв эмнэлэг Торлог шилэнцрийн өвчний цогц оношилгоо эмчилгээг өдөр бүр хийж байгаа аж. Ингэснээр нүдний салбарт нэлээд ахиц гарч, гадаадад болон хувийн эмнэлэгт хийдэг байсан өндөр төлбөртэй хагалгааг эрүүл мэндийн даатгалаар улсын эмнэлэгт хийлгэх боломжтой боллоо.

ФОТО МЭДЭЭ

Галын аюулгүй байдлын шалгалт дуусмагц гарсан түймэр



С.Батсайхан / ЗГМӨ

Нийслэлийн Онцгой байдлын газраас хүн ам олноор цуглардаг худалдаа, олон нийтийн байгууллагуудад гал түймрээс урьдчилан сэргийлэх, гамшгаас хамгаалах шалгалт явуулснаас 12-хон хоногийн дараа нийслэлийн төр захиргааны байр нь шатлаа. Уг нь шалгалтад нийслэлийн хэм-

жээнд үйл ажиллагаа явуулдаг 66 объектыг хамруулж, галын аюулгүйн дүрэм, норм, стандарт зөрчсөн 406 зөрчил илрүүлж, 25.2 хувийг газар дээр нь арилгуулсан аж. Бусад 95 зөрчлийг арилгуулахаар Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн албан бичгийг шийдвэр гаргах эрх бүхий

албан тушаалтанд хүргүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавин биелэлтийг хангуулан ажиллах үүрэг өгсөн байжээ. Харамсалтай нь шалгалт дуусангуут төв талбайн дэргэдэх объектод гал гарсан нь хяналт, шалгалтыг дахин нарийвчлах шаардлагатайг харуулж байна. [ЗГМ]

“МАНДАЛГОВЬ-ИМПЕКС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

“Мандалговь-Импекс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2019 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 15.00 цагт Улаанбаатар хотод “Монгол савхи” ХК-ийн хурлын танхимд болно.

Хаяг: Дорноговь аймаг, Сайнцагаан сум 7-р баг Бүртгэх өдөр: 2019.04.05

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

1. Компанийн 2018 оны үйл ажиллагааны тайлан

2. Компанийн ТУЗ-ийн тайлан
3. Аудитын хорооны тайлан
4. ТУЗ-ийн гишүүдийг сонгох
5. Тогтоолын төсөл

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралтай холбоотой бичиг баримтыг ажлын өдрүүдэд 09.00-17.00 цагийн хооронд “Монгол савхи” ХК-ийн байранд ирж танилцаж болно.

Хурал зохион байгуулах комисс.

Харилцах утас: 345959,88111316

“ЖУУЛЧИН ГОВЬ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

“Жуулчин говь” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2019 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 13.00 цагт Улаанбаатар хотод “Монгол савхи” ХК-ийн хурлын танхимд болно.

Хаяг: Улаанбаатар хот, Хан Уул дүүрэг, 2-р хороо Чингисийн өргөн чөлөө “Ажнай корпорацийн байр.

Бүртгэх өдөр: 2019.04.05

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

1. Компанийн 2018 оны үйл ажиллагааны тайлан

2. Компанийн ТУЗ-ийн тайлан
3. Аудитын хорооны тайлан
4. ТУЗ-ийн гишүүдийг сонгох
5. Тогтоолын төсөл

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралтай холбоотой бичиг баримтыг ажлын өдрүүдэд 09.00-17.00 цагийн хооронд “Монгол савхи” ХК-ийн байранд ирж танилцаж болно

Хурал зохион байгуулах комисс:

Харилцах утас: 345959

“МОНГОЛ САВХИ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

“Монгол савхи” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2019 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 10.00 цагт Улаанбаатар хотод “Монгол савхи” ХК-ийн хурлын танхимд болно.

Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2-р хороо, Ажнай корпорацийн байр

Бүртгэх өдөр: 2019.04.05

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны тайлан


2. Компанийн ТУЗ-ийн тайлан
3. Аудитын хорооны тайлан
4. ТУЗ-ийн гишүүдийг сонгох
5. Тогтоолын төсөл

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралтай холбоотой бичиг баримтыг ажлын өдрүүдэд 09.00-17.00 цагийн хооронд “Монгол савхи” ХК-ийн байранд ирж танилцаж болно

Хурал зохион байгуулах комисс:

Харилцах утас: 345757, 99051439, 99060160

Технологи



Дубайд хиймэл оюунт камерууд хүмүүсийн аз жаргалыг хэмжинэ

О. Мишээл
ЗГМ

Хиймэл оюун ухааны технологи санаанд оромгүй зүйлсэд хүртэл нэвтэрч байна. Арабын Нэгдсэн Эмиратын Дубай хотын зам, тээврийг удирдах газарт (RTA) байрлуулсан “ухаалаг” камеруудад тус байгууллагаар үйлчлүүлэгчдийн аз жаргалыг хэмжих ажил оноолоо. Дубайн зам, тээврийг удирдах газар нь

автомашин жолоодох эрхийн үнэмлэх олгох, тээврийн хэрэгслийг улсын бүртгэлд бүртгэх зэрэг үйлчилгээ эрхэлдэг юм.

Тус байгууллагад гуравдугаар сарын 11-ний даваа гарагаас ажиллаж эхэлсэн хяналтын систем хиймэл оюун ухаан бүхий өндөр нарийвчлалтай камеруудад суурилж байна. Сүлжээнд Wi-Fi юм уу Bluetooth-ээр холбогдож ажилладаг камерууд долоон метрийн зайнаас секундэд 30 кадрын хурдтайгаар

үйлчлүүлэгчдийн нүүр царайн зураг авдаг.

Тус албан газарт үйлчлүүлэхээс өмнө болон үйлчлүүлсний дараа хүмүүсийн нүүр царайн илрэлд хиймэл оюун ухаан дүн шинжилгээ хийж харьцуулна. Хиймэл оюун ухаан нүүр царайн илрэлд хийсэн судалгаандаа тулгуурлан үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг үнэлж дүгнээд “аз жаргалын индекс” заасан хязгаараас доошилсон тохиолдолд төрийн ажилтнуудад

тэр даруй дамжуулж анхааруулна. Мэдээллийн дагуу төрийн ажилтнууд сэтгэл дурамжхан байгаа үйлчлүүлэгчийн итгэлийг сэргээхэд шаардлагатай арга хэмжээ авах юм.

Зам, тээврийг удирдах газарт үйлчлүүлэгчдийн хувийн мэдээллийн халдашгүй байдлыг зөрчихгүйн тулд хяналтын систем хүмүүсийн зөвхөн нүүр царайн илрэлд дүн шинжилгээ хийдэг бөгөөд авсан гэрэл зургаа хадгалдаггүй. [ЗГМ]

БНХАУ-д 5G сүлжээгээр 3000 км зайнаас тархины мэс засал амжилттай гүйцэтгэлээ



БНХАУ гуравдугаар сарын 16-нд үүрэн холбооны 5G сүлжээ ашиглан алсын зайнаас Паркинсоны өвчтэй хүнд тархины нарийн мэс засал амжилттай гүйцэтгэлээ.

Тус улсын хамгийн өмнөд оршдог Хайнань дахь Хятадын Ардын Чөлөөлөх Армийн мэс засалч Лин Чипэй Бээжинд байгаа өвчтөнд алсын зайнаас мэс засал хийсэн юм.

Холбооны 5G сүлжээнд ухаалаг утсаар холбосон өндөр нарийвчлалтай монитор ашиглаж, мэс заслын багаж хэрэгслийг 3000 километр алсын зайнаас удирдаж ажиллуулсан мэс заслыг амжилттай дуусгажээ. Онлайн горимд хийсэн мэс заслын ажиллагаа гурван цаг үргэлжилсэн байна. Өндөр хурдтай холбооны ачаар мэс заслын ажиллагаанд хүлээлт, саатал гараагүйг мэс засалч тайлбарлав. Мэс заслын дараа мэдээ алдуулах эмийн үйлчилгээ гарсан хойно өвчтөн биеийн байдал сайн байгаагаа мэдэгдлээ.

Хятад улс 5G сүлжээ ашигласан

мэс заслыг энэ оны нэгдүгээр сард анх туршсан. Анхны туршилтын “өвчтөн” нь мэс засалчаас 50 километрийн алс байрлалтай лаборатори дахь гахайн торой байжээ.

Шинэ үеийн 5G сүлжээний технологи нь эн түрүүн асар нарийвчлалтай видео дүрс дамжуулахад түлхүү хэрэглэгдэх төлөвтэй байгаа. Энэ оны хаврын сар шинийн баярын гала концерт болон Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын ээлжит чуулганы үеэр 5G холболтыг өндөр нарийвчлалтай видео дохио дамжуулахад төдийгүй нэмэлт бодит байдлын технологи, хиймэл оюун ухааны гайхамшиг сонирхуулахад ашигласан юм.

Эдүгээ Хятадын үүрэн холбооны гол гурван оператор 5G технологийг хэрэглээнд нэвтрүүлэх туршилт, хөгжүүлэлтийн ажлыг далайцтай өрнүүлж байна. China Unicom компани Хятадын 17 том хотод 5G дохио дамжуулах туршилт саяхан дуусгасан. Тус компани энэ онд 5G сүлжээний технологид зургаагаас найман тэрбум юанийн хөрөнгө оруулахаар төлөвлөжээ. [ЗГМ]

Тийрэлтэт хөдөлгүүрийн чимээг шингээж чадах мета материал

АНУ-ын Бостоны их сургуулийн акустик инженерүүд агаараар дамжиж буй дуу чимээний 94 хувийг шингээх чадвартай өвөрмөц материал бүтээлээ. Эрдэмтдийн бүтээсэн ер бус шинэ хийц хэрэглээнд нэвтрэх юм бол, жишээ нь бараг дуугүй ажилладаг тийрэлтэт хөдөлгүүр бүтээж болно.

Сонирхолтой нь шинэ технологитой материалыг бүтээж үйлдвэрлэхэд хэцүү зүйл байхгүй. Эрдэмтэд тодорхой эх үүсвэрээс гарч буй дуу чимээг шингээх туршилт явуулахдаа ердийн 3D принтерээр бүтээсэн утгад хийц ашиглажээ. Цагариг хэлбэртэй уг хийц гадна захаараа эрчлээс хэзтэй. Хэрэглээнээс шалтгаалан дуу шингээгчийг ямар ч хэлбэртэй хийж болно. Жишээ нь бетон хананд цементээр нааж бэхлэх зориулалттай зургаан талт хэлбэртэй ч байж болно хэмээн эрдэмтэд тайлбарлав.

Дуу чимээ сонсогдохгүй болдгийн нууц нь уг материал дундуур агаар чөлөөтэй нэвтрэх мөртөө дуу чимээ нь анхны эх



үүсвэр лүүгээ ойдогт оршино. Жишээ нь ийм дуу шингээгчийг дроны сэнсэн доор байрлуулах тохиолдолд хөөргөх хүчинд саад учруулахгүй мөртөө сэнсний эргэлтээс үүсэх чимээг нь эсрэг чиглэлд ойх тул нөгөө талд нь байрлаж буй хүнд сонсогдохгүй. Технологийн энэхүү шинэ санаа хүмүүсийн амьдрал, үйлдвэрлэлийн бүхий л салбарт шинэ боломж нээж болзошгүй.

Инженерүүд шинэ нээлтээ Physical Review сэтгүүлийн 2019 оны нэгдүгээр сарын дугаарт нийтэлсэн юм. Энэхүү өвөрмөц технологийг Бостоны их сургуулийн Реза Гаффаривардаваг (гэрэл зургийн төвд), Стефан Андерсон (зүүн талд), Шин Зан (төвд, дээд талд), Жэйкоб Николайчук (баруун) нар хамтын хүчин чармайлтаар хөгжүүлсэн юм. [ЗГМ]

Утасны чихэвчний зах зээл ойрын жилүүдэд “тэсрэлт”-тэй өснө

Шинэ төрлийн, утасгүй чихэвчний эрэлт ойрын хэдэн жилийн дотор тэсрэлттэй өснө гэсэн дүгнэлтийг зах зээлийн судалгааны Counterpoint Research компани гаргалаа.

Утасгүй чихэвч гэсэн нэр томъёонд Apple-ын AirPods-тэй ижил төрлийн бүтээгдэхүүнийг багтаан ойлгож байгаа юм. Судалгааны тайланг үзвэл 2018 онд энэхүү төрлийн бүтээгдэхүүн дэлхийн зах зээлд

46 сая нэгж борлогджээ. Үүнээс 35 сая нь ердөө Apple AirPods загвар байгаа нь “алиман” эзэнт улс нийт зах зээлийн 75 хувийг атгаж буй хэрэг. Гэхдээ утасгүй чихэвчний зах зээл дараагийн

хэдхэн жилийн дотор үсрэнгүй өсөх төлөвтэй. Ердөө 2020 он гэхэд ийм хэрэгслийн нийлүүлэлт 129 сая ширхэгт хүрэх тооцоог тус компани гаргажээ. Тооцоо зөв байх аваас утасгүй чихэвчний борлуулалт одоогийнхоос гурав дахин өснө гэсэн үг.

Мөнгөн илэрхийллээр тооцож үзвэл утасгүй чихэвчний дэлхийн зах зээл ердөө 2021 он гэхэд 27 тэрбум ам.долларт хүрэхээр байгаа юм. Шинэ зах зээлд Apple-аас гадна Samsung, Bose, Jabra, Huawei, Bragi, LG зэрэг компани хүчтэй өрсөлдөгч болно хэмээн Counter Research тооцоолжээ. [ЗГМ]



ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2019.03.20

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: Хяналт удирдлагын төвийн тусгай зориулалтын өрөөнүүдийг тоноглох ажил

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР/ГЭРЭЭНИЙ ДУГААР: УСУГ-АУ-2019-86

Ус сувгийн удирдах газар эрх бүхий тендерт оролцогчдоос Хяналт удирдлагын төвийн тусгай зориулалтын өрөөнүүдийг тоноглох ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Тухайн тендерт эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр 50,000 /тавин мянган/ төгрөгний цахим тендерийн хураамж төлж оролцоно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

- Сүүлийн 2 жил буюу 2017, 2018 онуудын Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлнэ.
- Сүүлийн 2 жилд буюу 2017, 2018 онуудад ижил төстэй гэрээ хийсэн тухай мэдээлэл ирүүлнэ.
- Борлуулалтын орлого нь сүүлийн 2 жил /2017, 2018 / тус бүр тухайн ажлын төсөвт өртөгөөс дээш байх.
- Тендерийн хамт 2,730,000 /хоёр сая долоон зуун гучин мянга/ төгрөгийн тендерийн баталгаа ирүүлнэ.
- Хүчинтэй байх хугацаа: 2019 оны 07 дугаар сарын 01-ны өдрийг дуустал.

Тендерийг 2019 оны 04 дүгээр сарын 19-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө цахим системээр тендерийн материалаа ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2019 оны 04 дүгээр сарын 19-ны өдрийн 10 цаг 30 минут-аас нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Ус Сувгийн Удирдах газар, Токиогийн гудамж-5 өөрийн байр, С.Чинбаатар
Утас: 70157018-223

ZGM DAILY

FCHM improves basic equipment with ADB's fund

The project has been successfully implementing since 2013.

Some MPs announce establish political party

Party names and platforms will soon be submitted to the Supreme Court.

And Energy JSC to multiple sales revenue in 2019

The company's stock trades fell sharply in February with only five trades.

Top 20 Index increases 0.04 percent

Market cap stands at MNT 2.47 trillion.

ZGM: HIGHLIGHTS

POLITICS


The Cabinet to discuss the adoption of the new wastewater treatment plant's standard and other issues this week.

ECONOMY

Mongolia's foreign trade turnover amounted to USD 1.9 billion in February. Imports reached USD 837.5 million, which is USD 11.5 million higher compared to the same period of last year.

As of January 2019, the banking sector has granted 29 percent of loans, which is the largest amount, to commerce. Three percent were extended to mining and 4.2 percent to construction companies.

Top 20 Index increases 0.04 percent, to 20,800.01 points. MSE A Index goes up 0.01 percent, to 9,713.78 points. MSE B Index increases 0.01 percent, to 8,259.01 points. Market cap stands at MNT 2.47 trillion.



SOCIETY

Youth Development Center for Volunteer launches to support youth volunteers, increase participation, and prepare positive and creative citizens.

A winter tourism festival Nomads of Altai starts in Bayan-Ulgii province.

The 14th annual Ulaanbaatar Construction-2019 expo is to be held from March 15 to March 26.

Standing committee passes bills on foreign loans

Standing Committee on Budget discusses agreements with international organizations

Aminaa.U
ZGM

Parliamentary Standing Committee on Budget discussed the bill on the Government's rights to draw loans from foreign countries and international organizations, and passed the General Financing Program between the Government of Mongolia and the Asian Development Bank (ADB) and the draft amendment on the general agreement and conditions between the Mongolian Government and the Government of the Republic of Poland.

The Government has negotiated with the ADB to cooperate on finance, agriculture, educa-



Batsaikhan.S / ZGM©

tion, health, and agriculture in 2017-2020. In this context, USD 334 million will be allocated to Mongolia. The fund will be used in five projects including vegetables, border services, irrigation, regional roads, and free economic zones.

Plus, the European Bank for Reconstruction and Development (EBRD) offered to grant loans up to USD 300 million. The loan will have a maturity of 10-16 years with a moratorium of three years. Up until today, the EBRD has invested 99 projects

that amount to EUR 1.6 billion and the financing of this project was directed entirely towards private sectors.

However, Mongolia will use the current loan to build the road from Darkhan to Ulaanbaatar. The road will have four lanes and

The Government has negotiated with the ADB to cooperate on finance, agriculture, education, health, and agriculture in 2017-2020.

two lanes will be constructed by the ADB and the remaining two lanes will be built by the EBRD. The spending of remaining funds is still unclear, but the Finance Minister Khurelbaatar Chimed said that the total amount of fund will USD 300 million. [ZGM]

SOCIETY

ADB-financed renovation of First Central Hospital completes

Within the "Fifth Health Sector Development Project" funded by an MNT 1 billion soft loan from the Asian Development Bank (ADB), the Disinfection Department and Microbiology Laboratories of the First Central Hospital of Mongolia (FCHM) have been renovated.

The project was implemented to improve the safety of healthcare patients and staff at the hospital and was provided with MNT 238.5 million for maintenance and service, MNT

708.8 million for importing 29 types of hospital equipment.

"FCHM is a national provider of transplant treatments, surgery, and specialized professional referrals. The main importance of the project is to increase the type of required diagnosis, establish a sample fund, implement the control and preventive measures of infection, and provide clients and health workers with a quality health care," said the Minister of Health Sarangerel Davaajantsan at

the opening ceremony.

The Ministry of Health has been successfully implementing the project with the support from the ADB since 2013. The total cost of the project is USD 38.2 million, of which USD 30 million was financed from the ADB as a soft-loan and remaining USD 7.7 million was allocated from the Mongolian Government, and USD 480,000 investment was provided by the World Health Organization. [ZGM]

STOCK MARKET

And Energy JSC to double sales revenue in 2019

And Energy JSC's stock trades fell sharply in February with only five trades in the last month and a half. The company's sales revenue totaled MNT 910 million this year according to the company's CEO.

Overall this year, And Energy plans to double its sales revenue from last year to USD 2 billion. The company has estimated to generate approximately MNT 400 million in net profits in 2019 and

two major factors will play a role in its sales plan. As agreed, the company will supply MNT 400 million worth of goods to Erdenet Mining Corporation. And Energy company has built a new plant in Erdenet with the funds raised from the public. Secondly, the company will be inaugurating its plant on March 25.

Additionally, a shareholders' meeting of And Energy JSC has been scheduled on April 27. [ZGM]

ЦАХИМ ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2019 оны 03 дугаар сарын 20

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: Насанд хүрэгчдийн болон хүүхдийн аялалын иж бүрдэл, хөнжил нийлүүлэх

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: МИАТ/201901006

МИАТ ТӨХК эрх бүхий тендерт оролцогчдоос Насанд хүрэгчдийн болон хүүхдийн аялалын иж бүрдэл, хөнжил нийлүүлэх 3 багц бүхий цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь 50,000 төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жилийн буюу 2017, 2018 оны нийт борлуулалт тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байх,

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой эзэлийн хэмжээ: Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байх,

Сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байх,

Тендерийн хамт багц 1-т 2,920,000 төгрөгийн, багц 2-т 6,300,000 төгрөгийн, багц 3-т 480,000 төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа тус тус ирүүлнэ.

Цахим тендерт оролцогч цахим баталгаа гаргаж эрх бүхий арилжааны банкаар тендерийн нэг баталгаа гаргаж болох бөгөөд багц тус бүрийн баталгааны дүнг тодорхой бичсэн байх шаардлагатай.

Тендерийг 2019 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 11.00 цаг-аас өмнө цахим худалдан авах ажиллагааны систем /www.tender.gov.mn /-д өөрийн аж ахуйн нэгжийн цахим гарын үсэг /PKI/-ээр нэвтрэн орж PDF 1 файлаар цахим хэлбэрт шилжүүлэн ирүүлэх ба тендерийг 2019 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 11.30 цаг -т нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэхийг зөвшөөрнө. Дотоодны давуу эрх тооцох: Тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн мэдээллийг доорх хаягаар авч болно.

МИАТ ТӨХК

Хан-Уул дүүрэг, 10-р хороо,
Буянт-Ухаа 45, МИАТ ТӨХК-ийн төв байр, Хангамж, үйлчилгээний
хэлтэс 103 тоот
Утас: 70049860, факс: 70049919

POLITICS

Some MPs announce to set up political party

MPs Bold Luvsanvandan and Batzandan Jalbasuren, who were ousted by the Democratic Party last month, have officially announced to establish a new political party.

Mr. Bold said, "Last year, when several members of the Government have addressed the issue on dissolving the Cabinet, Batzandan Jalbasuren, Murat Dakey and I voted against it. As a result, the DP leaders decided to remove Batzandan from the party and imposed a

disciplinary penalty to Murat and me. I requested to leave the party because the DP should not be a communist party that expels its members. Today, we are setting up a new political party in cooperation with Mr. Batzandan. This party is open to everyone who has a passion to make Mongolia better. The purpose of our party is to guide people to power, wealth, and the future of the people. Party names and platforms will soon be

submitted to the Supreme Court."

MP Mr. Batzandan added, "It has been 30 years since the establishment of a democratic society in Mongolia. However, external debt has skyrocketed and the poverty rate has reached 30 percent. Majority of Mongolia's wealth has been concentrated among the minority. There is a need to protect Mongolia and we are officially announcing the establishment of a new political force for this purpose. The mystery of the murder case of Zorig Sanjaasuren will be revealed this week. Two years ago Bold Luvsanvandan and I were addressing the violation of the law on this case. The 49 percent issue of the Erdenet Mining Corporation has also been mentioned two years ago. MPs who worked with Parliament Speaker in Switzerland last week have brought information about politicians who hold offshore accounts." [ZGM]

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ СӨНИН

II улирлын захиалга үргэлжилж байна



Онлайн захиалга

- Улиралд: 5000₮ (62 дугаар)
- Хагас жилд: 10 000₮ (124 дугаар)
- Жилд: 15 000₮ (248 дугаар)



Хэвлэмэл захиалга

- Улиралд: 30 000₮ (62 дугаар)
- Хагас жилд: 60 000₮ (124 дугаар)
- Жилд: 120 000₮ (248 дугаар)



Хосолмол захиалга

(Хэвлэмэл + Онлайн)

- Улиралд: 32 000₮ (62 дугаар)
- Хагас жилд: 65 000₮ (124 дугаар)
- Жилд: 125 000₮ (248 дугаар)



tdbpay

Та доорх QR кодыг уншуулан
гүйлгээний утга хэсэгт и-мэйл хаяг,
утасны дугаараа бүртгүүлэн Засгийн
газрын мэдээ сонинг өөрийн хүссэн
хэлбэрээр захиалаарай.

QR код ашиглахгүйгээр төлбөр хийх бол:

УЛААНБААТАР
ХОТЫН БАНК

2600092954

ТООТ ДАНСАНД МӨНГӨӨ ТУШААНА УУ.

zgm.mn

ZGMmn

zasagco

zgm.mn

70103131 99903581

Өдрийн хэмнэл

ТВ ХӨТӨЛБӨР



- 07.00 "Өглөө" хөтөлбөр /шууд/
- 14.10 "Зогсохгүй" Гавьяат жүжигчин, дуучин Ө.Уянга
- 17.15 120/80 эрүүл мэндийн нэвтрүүлэг "Цэсний чулуу"
- 18.30 Иргэдийн эрхзүйн боловсролд /шууд/
- 19.30 Сурах бичиг хэрхэн яаж...
- 21.10 "DeFacto" мэтгэлцээн /шууд/

Bloomberg TV Mongolia

- 07.00 "Өсөлтийн замд" нэвтрүүлэг
- 09.00 Бизнесийн хэмнэл мэдээний хөтөлбөр
- 11.00 #Made in Mongolia Баримтат цуврал нэвтрүүлэг
- 18.00 Бизнесийн төв цэг Мэдээний хөтөлбөр давталт
- 20.00 Блумбергийн ярилцах цаг нэвтрүүлэг

- 23.00 Мөнгөний урсгал Мэдээний хөтөлбөр-давталт

БОЛОВСРОЛ HD

- 09.55 Хөгжмийн завсарлага
- 12.10 "Да Винчи ба Митраагийн тайлаглашгүй нууцууд" ОАК 1.7-р анги
- 14.10 "Мөнгөтэй зочин" шоу нэвтрүүлэг
- 15.50 Хөгжмийн цаг
- 20.50 "Гал тогоо" шоу нэвтрүүлэг
- 22.00 "Тангараг" ОАК 1.7-р анги

МОНГОЛTV

- 12.00 Хөтөч мэдээллийн хөтөлбөр
- 13.30 Chart news 44-р хэсэг
- 16.00 "The Voice of Mongolia" шоу нэвтрүүлэг 18-р хэсэг
- 19.00 Оргил цаг мэдээллийн хөтөлбөр
- 20.00 "Бүтэлгүй Севкат" ТОАК 12-р анги
- 21.00 "Шивэгчний өчил" ОАК /season1/ 6-р анги

ЗУРХАЙ



Билгийн тооллын 14
Хаврын дунд улаагчин туулай сарын гурван хөх мэнгэтэй улаан луу өдөр **Үс засуулбал:** Эд мал арвидна.
Наран ургах, шингэх: 06.55-19.03
Барилдлага: Үл зохилдох
Шүтэн барилдлага: Хүрэлцэхүй
Суудал: Үс

Аргын тооллын гуравдугаар сарын 20, Буд гараг. Билгийн тооллын 14, харцага одтой, улаан луу өдөр.


Өдрийн наран 06.55 цагт мандан, 19.03 цагт жаргана. Тухайн өдөр хулгана, бич жилтнээ аливаа үйл хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, бие энхрийлүүштэй. Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба лус тахиx, хур оруулах, ээтгэрийг номхотгох, хөгжмийн эмсэг урлах, дарханы үйлд сайн. Гүүр тавих, газар ухах, цөөрөм байгуулахад муу. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одогсон зүүн зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эд, мал арвидна.



Олон улсын цирк
Хаана: Монголын үндэсний АСА цирк
Хэзээ: 2019.03.23-наас
Тасалбарын үнэ: ₮15-35 мянга



Япон поп соёлын өдөрлөг-2019
Хаана: Corporate Convention Centre
Хэзээ: 2019.03.24-нд
Тасалбарын үнэ: ₮10 мянга



У.Шекспир "Ромео, Жульетта"
Хаана: УДЭТ
Хэзээ: 2019.03.27-29-нд
Тасалбарын үнэ: ₮10-30 мянга

ОНЦЛОХ ҮЗВЭР

"U-23" АЗИЙН АШТ-ИЙ УРЬДЧИЛСАН ТОГЛОЛТ



2020 онд Тайланд улсад болох "U-23" хөлбөмбөгийн Азийн аварга шалгаруулах тэмцээний урьдчилсан тоглолтууд Монголд болно. Тодруулбал, Азийн аварга шалгаруулах тэмцээний 23 хүртэлх насны ангилалд G хэсэгт өрсөлдөх БНАСАУ, Хонконг, Сингапур, Монгол Улсын баг энэ сарын 22-26-ны өдрүүдэд Монголын хөлбөмбөгийн холбооны цэнгэлдэх хүрээлэнд тоглох юм. Энэ хэсэгт багтсан БНАСАУ-ын баг гурван жил шигшээд шалгарч байсан туршлагатай. Харин нөгөө гурван улсын баг Азийн аварга шалгаруулах тэмцээний урьдчилсан шалгаруулалтыг давж байсан удаагүй. Азид дээгүүрт өрсөлддөг баг тамирчидтай монголчууд хэрхэн тоглохыг сонирхохыг хүсвэл нэг тоглолтын тасалбарын үнэ ердөө 5000 төгрөг, багцаар нь авбал 10 мянган төгрөгийн үнэтэй.

Манай улсын хөлбөмбөгчид Германы мэргэжилтэн Майкл Вайссаар ахлуулан БНХАУ-ын Кумминг хотод бэлтгэлээ базаагаад ирсэн. Тэд энэ жил ДАШТ-ий урьдчилсан шатны чухал тоглолтод оролцох юм. Хөлбөмбөгийн спортод хорхойсдог хэн бүхэн нутаг нэгт залуусаа дэмжихийг уриалж, тоглолтын хуваарийг танилцуулъя.

2019.03.22-нд
Хонконг – Сингапур 13.00 цаг
Хойд Солонгос – Монгол 17.00

2019.03.24-нд
Сингапур – Хойд Солонгос 13.00
Монгол – Хонконг 17.00

2019.03.26-нд
Хойд Солонгос – Хонконг 13.00
Сингапур – Монгол 17.00

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

III.20	III.21	III.22	III.23	III.24
-3° -13° 10 м/с	0° -15° 7 м/с	3° -12° 8 м/с	7° -10° 7 м/с	7° -7° 8 м/с
Үүл багасна	Багавтар үүлтэй	Үүл багасна	Багавтар үүлтэй	Үүлшинэ




ФОТО АГШИН



Чингэлтэйн эцэст 12.9 саяар барьсан цэцэрлэгт хүрээлэн өвөлдөө мөстөж, зундаа шалбаагт автдаг.

С.Батсайхан / ЗГМӨ

ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ

1	2	3	4	5	6
7			8		
9	10		11		12
13			14		

БОСООГООР:

1. Найрсаг
2. Зэрэг, дугаар
3. Дутуу нойртой байдал
4. Казахстаны хуучин нийслэл хот
5. ... сайт

6. ЗХУ (хуучнаар)-ын Ардын жүжигчин, нэрт алиалагч агсан
10. Индиантай романуудаараа алдаршсан зохиолч
12. Адууны хүзүү

орчмын үс

Хөндлөнгөөр:

1. Богд хаант Монгол Улсын цэргийн яамны анхны сайд
- Г.Гомбосүрэнгийн цол

7. Үүдэн шүд нь унаж онгойсон байдал
8. Манай улсад импортоор ирдэг байсан ЗХУ-ын тамхины нэр
9. Сонор
11. Сэлэнгэ аймгийн сум
13. Дотогш гэдгийн эсрэг утга
14. Үхрийн зүс

Өмнөх дугаарын хариу / 03.18

		О	С	А	М	А		
Х	Б	Е	Э	Э	С			
А	Г	А	А	Р	Н	А	М	Б
Н	Д	Е	Г	Н	Э	А		
О	Т	Г	О	Н	Т	Э	Н	Г
Й	А	А	А	Р	Ч	Б		
		Н		Ф		И		
		А	М	Г	А	Л	А	Н

ЗГМ: СУДОКУ

						3		
	3		2					5
1	2	4						
						3	9	7
3		9				1		
	5	2	6					
			5	7	9			1
5	1							
9								6

5	1	7	8	2	3	9	4	6
6	2	9	5	7	4	3	8	1
8	4	3	6	9	1	2	7	5
3	6	1	9	4	5	8	2	7
7	5	8	1	3	2	6	9	4
4	9	2	7	8	6	5	1	3
1	7	5	2	6	8	4	3	9
9	8	4	3	5	7	1	6	2
2	3	6	4	1	9	7	5	8

(Анхны дугаарыг хар)



ГАЛТ ТЭРЭГНИЙ ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-МОСКВА	13.50	14.28
МОСКВА-УБ	21.35	07.30
УБ-ЭРХҮҮ	21.10	02.40
ЭРХҮҮ-УБ	15.35	06.20
УБ-ЭРХҮҮ	21.10	02.40
УБ-СҮХБААТАР	21.15	05.12
СҮХБААТАР-УБ	20.55	05.03
УБ-ЭРДЭНЭТ	20.30	07.45
ЭРДЭНЭТ-УБ	19.10	05.48



НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-СӨҮЛ	07.45	12.05
СӨҮЛ-БЕРЛИН	13.20	16.05
УБ-БЭЭЖИН	17.15	19.30
БЭЭЖИН-УБ	20.30	23.00
УБ-ХОНКОНГ	07.50	12.25
ХОНКОНГ-УБ	13.25	18.05
УБ-ТОКИО	08.55	14.30
ТОКИО-УБ	15.30	20.25

ЗАРНА

1-р хороолол, Цамбагаравт маш сайн байрлалтай 700 м2 3 давхар объект хямдхан зарна. Сургууль, цэцэрлэг, эмнэлэг, зочид буудал, бүх төрлийн үйлдвэр үйлчилгээ явуулах боломжтой. Үнэ 1м2 нь 1,8 сая төгрөг.

Утас: 99115920

ЭДИЙН ЗАСАГ

Тэрбумтан Амбани \$80 саяын торгуулиа ахаараа төлүүлж шоронгоос аврагдав

2015 онд "хасах тэрбумтан" хэмээх хочтой болж, ганц тэрбум ам.доллартой үлджээ.

> 10

Нефтийн баялаг Норвегийн бодлогын хүүг өсгөнө

Скандинавын хамгийн баян эдийн засаг энэ долоо хоногт бодлогын хүүгээ дөрвөн жилийн дээд түвшинд хүргэх төлөвтэй байна.


> 10

Сөрөг мэдээллүүд мөнгөн гуйвуулгад хүндрэл үүсгэж байна

Үйлчилгээндээ баримталж буй хамгийн гол зарчим бол "Харилцагчаа таньж мэдэх"

> 11

АНУ-ын фермерүүд Хятадад ургацаа худалдахыг хүсчээ



Айзис Альмейда

БНХАУ "эрчтэй" өрнөж буй худалдааны хэлэлцээний хүрээнд АНУ-аас хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг "сонирхол татахуйц хэмжээгээр" худалдаж авах санал тавьсан ч биотехнологи зэрэг салбарт бэрхшээл байсаар байгааг АНУ-ын Хөдөө Аж Ахуйн сайд Сонни Пердью мэдэгдлээ.

Флорида муж улсын Амелиа Айлэндэд хуралдсан Үндэсний Үр Тариа, Тэжээлийн Холбооны жил тутмын хуралдаан дээр хөдөө аж ахуйн салбарт зарим зүйлсийг хэдийн тохиролцсон ч БНХАУ-аар хүлээсэн үүргийг нь мөрдүүлэхийн тулд АНУ олон асуудлыг нарийн тодорхойлох шаардлагатайг сайд өгүүлсэн юм.

Цаашид хөдөө аж ахуйн биотехнологийн инновац тарифын саад тотгорт баригдалгүйгээр Хятад руу чөлөөтэй урсахаас АНУ болгоомжилж байгааг тэрбээр мөн дурдлаа.

"Хятад хөдөө аж ахуйн

бүтээгдэхүүн худалдан авах тун сонирхолтой зарим санал тавьсан. Гэхдээ тохиролцоо ид үргэлжилж буйтай уялдан бид хэлэлцээр байгуулж чадахааргүй зүйлсээр хоосон найдлага төрүүлмээргүй байна" хэмээн сайд тайлбарлав. Хоёр тал биотехнологийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатайг тэрбээр онцлон анхааруулсан юм.

Хөдөө аж ахуйн яриа хэлэлцээ Хятад улс АНУ-аас зөвхөн шар буурцаг худалдан авах асуудал төдий биш. Эрдэнэ шиш, тутарга зэрэг үр тариа, тахианы махыг оролцуулаад бүх төрлийн малын мах худалдан авах ёстой хэмээн ноён Пердью үзэж байна. Хэлэлцээний дүнд Бээжин жил тутам АНУ-аас 30 тэрбум ам.долларын хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн нэмж авах учиртай. АНУ зарим бүтээгдэхүүнтэй холбоотой худалдааны бус саад тотгорыг авч хаях санал тавьсны зэрэгцээ үхрийн мах нийлүүлэх яриа хэлэлцээнд ахиц гарсныг сайд

нэмж мэдэгдлээ.

БНХАУ яриа хэлэлцээг урагшлуулахаар эрмэлзэж буйн илрэл болгон сүүлийн хэдэн сард АНУ-ын шар буурцагийн зах зээлд хэдийн багтай нэвтэрч авсан. Харин АНУ-ын фермерүүд худалдааны дайны улмаас агуулахад дараастай үлдсэн, өнгөрсөн улирлын арвин ургацыг одоогийнхоос их хэмжээгээр худалдан аваасай хэмээн хүлээж сууна.

Шар буурцагт оноосон тариф нь АНУ-ын хөдөө аж ахуй Хятадаас хэт хамааралтай болсны илрэл хэмээн сайд үзлээ. АНУ-ын хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнээр үйлчлүүлэгчдийн хүрээг Малайз, Филиппин, Энэтхэг, Вьетнам, Тайландаас тэлэх нь чухлыг сайд онцлон дурдаж байлаа. Одоогоор бүгд нийлээд Хятадын зах зээлийн хэмжээнд хүрч чадахгүй байгаа эдгээр улсад нэвтрэх нь өрсөлдөгчдийг төрүүлэх сайн талтай хэмээн ноён Пердью

өгүүлэв.

"Энэхүү хүрээг өргөжүүлэхийг хичээхийн хамт Хятадын эрэлтийг ч аль болох дэмжинэ" хэмээн тэрбээр өгүүлсэн юм.

АНУ нь хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн ахиу худалдаж авахыг шахаж буйтай хавсруулан худалдааны асуудалд бүтцийн шинэчлэл өрнүүлэх шаардлага мөн тавьж байгааг АНУ-ын Худалдааны Төлөөлөгчийн Оффисын хөдөө аж ахуйн асуудлаар хэлэлцэн тохирогч гол хүн Грег Дауд Флоридад болсон хэвлэлийн хурал дээр тайлбарлав. Азийн улсын дотоодын татаас, нөхөн олговор, худалдааны тарифын квот (TRQ) зэрэг нь шийдвэрлэх ёстой асуудал болж буйг Дауд дурдлаа.

Хятадын тарифын квотод улаан буудай, эрдэнэ шиш, тутарга ордог. Хятадын тал хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс 9.64 сая тонн улаан буудай, 7.2 сая тонн эрдэнэ шишийг АНУ-аас тус улсад импортолж чадаагүйг сайд шүүмжлэв. "Зарим улс тарифын квотоор хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байгаа нь бидний урмыг хугаллаа" хэмээн Дауд өгүүлсэн нь худалдааны яриа хэлэлцээнд хамаатай Канадыг давхар хэлсэн хэрэг байлаа.

БНХАУ 2018 онд импортоор 124 тэрбум ам.долларын хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн худалдаж авсан. Тэгсэн мөртөө уг импортод АНУ-ын эзлэх хэмжээ 20 орчим тэрбум ам.доллар байгаа нь чамлалттай хэмээн сайд үзсэн юм.



Дэлхийн хамгийн үнэтэй хотууд тодорлоо

Алекс Миллсон

Бизнесийн мэдээллийн Economist Intelligence Unit-ээс дэлхийн хотуудыг амьжиргааны өртгөөр нь шалгаруулдаг Worldwide Cost of Living судалгаанд таван жил тэргүүлсэн Азийн арслан хот – Сингапур энэ онд Парис, Хонконгийн хамт шинэ жагсаалтыг тэргүүллээ. Цюрих, Женев шилдэг тавд, Нью Йорк, Лос Анжелес тус бүр долоо, аравдугаар байранд оров. Ам.долларын ханш суларснаас шалтгаалан сүүлийн хоёр хот 2018 онд 13, 14-р байр эзэлж байжээ.



Boeing-ыг шалгах ажиллагаа хоёр дахь ослоос ч өмнө эхэлсэн байжээ

Алан Ливайн, Питер Робисон

Boeing компанийн 737 Max онгоцонд зорчигч тээвэрлэх гэрчилгээ хэрхэн олгосныг АНУ-ын холбооны эрх баригчид Этиопид шинэ тийрэлтэт онгоц сүйрсэн ослоос бүр өмнө мөрдөн шалгаж эхэлснийг уг шалгалтад ойр эх сурвалж уламжлав.

Lion Air 737 Max 8 онгоц 10 дугаар сарын 29-нд Жакартагаас хөөрөөд удалгүй сүйрсэн. Уг ослын дараахан гарсан мэдээллийн дагуу холбооны эрх баригчид шалгалт эхлүүлснийг нэрийг нь дурдахыг зөвшөөрөөгүй дээрх эх сурвалж тайлбарлаж байна.

Гуравдугаар сарын 10-нд Аддис Абебагийн ойролцоо Ethiopian Airlines 737 Max 8 онгоц осолдож 157 хүний амь үрэгдсэний дараа мөрдөн шалгах ажиллагаа бүр ч эрчимжсэн байна. АНУ-ын Хууль Зүйн Яамтай холбоотой ажиллаж, аудитын болон эрүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг Тээврийн Яамны харьяа Ерөнхий мөрдөн байцаагчийн оффис уг ажлыг хариуцан гүйцэтгэж байна.

Одоогоор АНУ-ын Хууль Зүйн Яам 737 Max онгоцыг бүтээж хөгжүүлсэн ажлын талаарх мэдээлэл цуглуулж буйн зэрэгцээ Boeing-ыг тангарагтны шүүхэд дуудахаар төлөвлөж байгааг уг мэдээллийн нийтэд зарлах үүрэг хүлээгээгүй эх сурвалж дамжууллаа. Хууль зүйн яамны Эрүүгийн мөрдөх хэлтэс тайлбар өгөхөөс татгалзав.

Үүсээд буй хэрэгт тангарагтны шүүх оролцох гэж байгааг Wall Street Journal мөн мэдээллээ. АНУ-ын зохицуулах байгууллага нисэх онгоцны аюулгүйн үнэлгээний ажлын ихэнхийг Boeing-д өөрт нь хариуцуулсны хариуд үйлдвэрлэгч компани аюулгүйн "цоорхой"-той анализ дүгнэлт гаргасныг Seattle Times сонин ням гарагт мэдээлсэн юм.

Мөрдөн шалгах ажиллагаатай холбогдуулан тайлбар өгөхөөс Boeing, Тээврийн яам татгалзлаа. Ethiopian Airlines-ын осол өнгөрсөн аравдугаар сарын Lion Air Flight 610-ынхтой "илт төстэй" байгааг хар хайрцагны бичлэг харуулж өгснийг Этиопын тээврийн сайд ням гарагт мэдэгдсэн юм.

Хонконгийн валютын интервенц нэг тэрбум ам.долларт дөхлөө



Ричард Фрост

Валютаа аврах Хонконгийн хамгаалалтын зардал эрс өссөн нь долоо хоногийн сүүлээр болсон арилжааны үеэр онцгой бүсийн долларын ханшийг гацаалаа. Засаг захиргааны онцгой бүсийн

төв банкны үүрэг гүйцэтгэгч – Хонконгийн валютын хэрэг эрхлэх газар (Hong Kong Monetary Authority) даваа гарагт 2.01 тэрбум хонконг доллар (256 сая ам.доллар) худалдаж авсныг Bloomberg мэдээлж байна. Хонконг доллар нь

бага хувьтай бодлогын хүүгээсээ шалтгаалж хөрөнгө оруулагчдын сонирхлыг татах нь муудсан. Валютын хэрэг эрхлэх газар энэ сар гарсаар нийт 7.4 тэрбум хонконг доллар худалдаж аваад байна.



3-р сарын 21, 28-ны өдрүүдэд
1'100'000₮



11 333 999

Эдийн засаг

Тэрбумтан Амбани \$80 саяын торгуулиа ахаараа төлүүлж шоронгоос аврагдав

Абхрай Сингх

Энэтхэгийн тэрбумтан Анил Амбани Ericsson компанид 80 сая ам.доллар төлөх шүүхийн шийдвэрийн эцсийн хугацаа дуусахаас өмнө амжиж төлбөрөө хийжээ. Гайхалтай нь хүнд байдалд орсон тэрбумтаны ах Мукеш, бэргэн нар нь уг мөнгийг Reliance Communications компаниасаа төлсөн байна. Амбани хувийн баталгаа өгсөн ч торгууль төлөөгүйн улмаас хэрэг даамжирч гурван сар шоронд суухад хүрээд байв. Тэрээр “Хүндэт ах Мукеш, бэргэн эгч Нита нартаа намайг хүнд байдалд орох үед дэмжсэн чин сэтгэлээсээ баярласнаа илэрхийлэе. Цаг үеэ олсон тусламж үзүүлсэн нь манай гэр бүлийн хүчирхэг үнэт зүйлийн ач холбогдлыг харуулсан явдал боллоо. Гэр бүл маань өнгөрснөө даван туулж, ийм

алхам хийсэнд гүнээ талархаж байна” хэмээн мэдэгдэв. Амбанийн телеком, эрчим хүч, дэд бүтцийн бизнес өрийн дарамтад орсон нь шүүхийн шийдвэрээс харагдана.

Bloomberg-ийн өгөгдлөөс үзэхэд түүний хөрөнгө 2008 онд 31 тэрбум ам.доллаар үнэлэгдэж байснаа 300 сая боллоо багассан нь Энэтхэгийн нэр хүндтэй, баян гэр бүлийн нэг гишүүний хачирхалтай уналтын үзүүлэлт боллоо. Анилийн уналт 52.9 тэрбум ам.доллаар хэмжигдэж байхад ах Мукеш нь жилийн дотор хөрөнгөө 8.6 тэрбумаар арвижуулсан. Ах дүү хоёр эцгээ нас барсны дараа нэлээд тэмцэлтэй явж ирсэн аж.

Анилийн энэхүү “ядуурал” орчин үеийн баячуудын зэрэглэлийн түүхэнд Softbank-ны хувьцаанаас \$70

тэрбумыг алдсан Японы Масаёшитэй дүйхүйц хэмжээтэй юм. Бразилын Эйке Батиста арван жилийн өмнө 30 тэрбумтай байсан боловч таваар, логистикийн эзэнт гүрэн нь өрөнд баригдаж, хувьцааны арилжааны золиос болж нурсан юм. Тэрээр 2015 онд “хасах тэрбумтан” хэмээх хочтой болж, ганц тэрбум ам.доллартой үлджээ.

Зохицуулалтын будилааны улмаас Анилийн хамгийн том хэлцэл хойшлогдсоны дараа Ericsson зэрэг зээлдүүлэгчид өмнөх өрөө нэхж эхэлсэн байна. Шведийн компани шүүхээр шаргуу явсны эцэст зарга мэдүүлсэн хохирлынхоо талыг буюу 80 саяыг авах шийдвэр гаргуулж, ноён Амбани хувийн баталгаа өгсөн байна. Тэрээр амлалтаа хэрэгжүүлээгүй тул шүүхээс эцсийн хугацаа

тогтоож, Энэтхэгийн хамгийн баян зээлдэгчид шоронд хорих сануулга өгсөн ер бусын хэрэг байв. Тус улсын банкуудад муу зээлийн хэмжээ хэрээс хэтэрснээс шалтгаалан эрх баригчид болон шүүхээс ийнхүү хатуу ханджээ. Ах дүү Амбани нар эцгийнхээ компанид захирлаар ажиллаж байгаад 2002 онд нас барахад нь хяналтын төлөө тэмцэлдэж эхэлсэн аж. 2005 онд тэд компанийг хуваах тохиролцоонд хүрчээ. Анил телеком, эрчим хүч, санхүүгийн үйлчилгээ гэх мэт шинэ бизнесийг авсан байна. Харин Мукешийн нефть, химийн бизнес хөгжин цэцэглэж, Reliance Jio Infocomm нэртэй компани байгуулан телекомд буцаж ирсэн явдал дүүгийнх нь RCom компанид цохилт болсон билээ.



Нефтийн баялаг Норвегийн бодлогын хүүг өсгөнө



Свейнан Слейр

Норвегийн төв банк хөршүүдээ ардаа орхилоо. Скандинавын хамгийн баян эдийн засаг энэ долоо хоногт бодлогын хүүгээ дөрвөн жилийн дээд түвшинд хүргэх төлөвтэй байна. Энэ нь есдүгээр сараас хойш хийсэн хоёр дахь алхам бөгөөд төв

банкны захирагч Ойстен Олсены бодлого тэгээс доош хүүтэй Швед, Германаас өөр байгаа нь харагдана. Норвегийн эдийн засгийн сэргэлт энэ оны хоёрдугаар хасагт бодлогын хүүгээ дахин өсгөх алхам хийхэд хүргэх магадлалтай.

Norge банк бодлогын хүүгээ

нэг хувьд авчирч байгаа нь Норвегийн эдийн засаг бүрэн хүчээрээ урагшилж буйн дохио гэж шинжээчид тэмдэглэв. Ажилгүйдэл гурван хувь дээр тогтож, инфляц зорилтот түвшнээс дээш гарчээ. Үүний сацуу 2018 оны сүүлээс газрын тосны үнэ 34 хувь дээшлээд

байгаа. Эдийн засгийн ийм хүчтэй үзүүлэлтүүдийг үл харгалзан Норвегийн крон суларч, өмнөх оны дээд ханшаас гурван хувиар доошлов.

Энэ нь ноён Олсенд экспортод нөлөөлөхгүйгээр хүүгээ өсгөх боломж олголоо. Norge банк хэт зээлээс сэргийлэхийн тулд

хүүг таамгаас жаахан дээгүүр барих бодлого баримталж буй. Нөгөө талаас Норвегийн бодлого боловсруулагчид дэлхийн эдийн засагт учирч болзошгүй эрсдэлүүдийг тооцсон байна. Европын төв банк дэмжлэгийн бодлогоо дээшлүүлж, хүүг өсгөх төлөвлөгөөгөө хойшлуулснаар еврогийн ханш 2013 оноос хойш хамгийн доод түвшинд ирсэн. Түүнчлэн Шведийн төв банк ч мөн өсөлт ба инфляц доогуур байгааг харгалзан оны сүүлээр төлөвлөгдсөн чангатгах арга хэмжээг хойшлуулах төлөвтэй байна.

Ноён Олсен зээлд дарагдсан хэрэглэгчдэд шилжилтийн хугацаа өгөхийн тулд хүүг аажмаар өсгөнө гэдгээ зарласан. Svedbank-ны эдийн засагч Марлен Гранеруд энэ талаар “Төв банкууд хүүгээ өсгөхөө хойшлуулах буюу зогсоож байгаа цаг үед Норвегийн банк үүнийг дангаар хийж чадна

гэж бодож байна. Кроны ханш чангарах эрсдэл хязгаартай байгаа ч бусад төв банкуудтай харьцуулахад арай чанга бодлого барьж байгаа нь өөрөө аажуу алхам хийхийг шаардаж байна” хэмээн дүгнэв.

Түүнчлэн Handel бакны ерөнхий эдийн засагч Мариус Хов “Norge банк хүүгээ багаар өсгөж байгаа нь ирэх есдүгээр сард дахин өсгөх магадлалыг нэмэгдүүлж байна. Гэхдээ бидний бодлоор оны эцсээс наана үр дүн нь мэдэгдэхгүй. Цаашлаад тус банк олон улсын хүчин зүйлээс шалтгаалан өсөлтийн хэмжээгээ багасгах боловч буцаан бууруулах нь юу л бол” хэмээн таамаглав. Хүүгийн сүүлийн өсөлтийг зах зээл болон айл өрхүүд харьцангуй сайн давж гарсан гэж шинжээчид үзэж буй. Тэдний ярьснаар хүүг цаашдаа өсгөх чиглэл рүү явлаа ч маш аажуу алхам хийх нь тодорхой байна.

ЦАХИМ ТЕНДЕРИЙН УРИЛГА

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: Зорчигчийн үйлчилгээний 1 удаагийн цаасан хэрэглэл нийлүүлэх
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: МИАТ/201901003

МИАТ ТӨХК эрх бүхий тендер оролцогчдоос Зорчигчийн үйлчилгээний 1 удаагийн цаасан хэрэглэл нийлүүлэх 2 багц бүхий цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь **50,000 төгрөг**, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендер оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жилийн буюу 2017, 2018 оны нийт борлуулалт тендер санал болгож буй үнийн дүнгээс багагүй байх,

2. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Тендер санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байх,

3. Сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: Тендер санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй байх,

Тендерийн хамт багц 1-т **9,867,000 төгрөгийн**, багц 2-т **5,912,000 төгрөгийн** дүнтэй тендерийн баталгаа тус тус ирүүлнэ.

Цахим тендер оролцогч цахим баталгаа гаргах эрх бүхий арилжааны банкаар тендерийн нэг баталгаа гаргаж болох бөгөөд багц тус бүрийн баталгааны дүнг тодорхой бичсэн байх шаардлагатай.

Тендерийг **2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 11.00 цаг-аас өмнө** цахим худалдан авах ажиллагааны систем /www.tender.gov.mn /-д өөрийн аж ахуйн нэгжийн цахим гарын үсэг /PKI/-ээр нэвтрэн орж PDF 1 файлаар цахим хэлбэрт шилжүүлэн ирүүлэх ба тендерийг **2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 11.30 цаг**-т нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэхийг **зөвшөөрнө.**

Дотоодны давуу эрх **тооцохгүй.**

Сонирхсон этгээд тендерийн мэдээллийг доорх хаягаар авч болно.

МИАТ ТӨХК

Хан-Уул дүүрэг, 10-р хороо, Буянт-Ухаа 45,
МИАТ ТӨХК-ийн төв байр
Хангамж, үйлчилгээний хэлтэс 103 тоот
Утас: 70049860, факс: 70049919

ЦАХИМ ТЕНДЕРИЙН УРИЛГА

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: Агаарын хөлгийн үйлчилгээний 1 удаагийн уут хэрэглэл нийлүүлэх
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: МИАТ/201901001

МИАТ ТӨХК эрх бүхий тендер оролцогчдоос Агаарын хөлгийн үйлчилгээний 1 удаагийн уут хэрэглэл нийлүүлэх цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь **50,000 төгрөг**, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендер оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жилийн буюу 2017, 2018 оны нийт борлуулалт тендер санал болгож буй үнийн дүнгээс багагүй байх,

2. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Тендер санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байх,

3. Сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: Тендер санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй байх,

Тендерийн хамт **1,874,000 төгрөгийн** дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Цахим тендер оролцогч цахим баталгаа гаргах эрх бүхий арилжааны банкаар тендерийн баталгаа гаргаж болох бөгөөд баталгааны дүнг тодорхой бичсэн байх шаардлагатай.

Тендерийг **2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 11.30 цаг-аас өмнө** цахим худалдан авах ажиллагааны систем /www.tender.gov.mn /-д өөрийн аж ахуйн нэгжийн цахим гарын үсэг /PKI/-ээр нэвтрэн орж PDF 1 файлаар цахим хэлбэрт шилжүүлэн ирүүлэх ба тендерийг **2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 11.50 цаг**-т нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэхийг **зөвшөөрөхгүй.**

Дотоодны давуу эрх **тооцохгүй.**

Сонирхсон этгээд тендерийн мэдээллийг доорх хаягаар авч болно.

МИАТ ТӨХК

Хан-Уул дүүрэг, 10-р хороо, Буянт-Ухаа 45,
МИАТ ТӨХК-ийн төв байр
Хангамж, үйлчилгээний хэлтэс 103 тоот
Утас: 70049860, факс: 70049919

ЦАХИМ ТЕНДЕРИЙН УРИЛГА

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: Зорчигчийн үйлчилгээний 1 удаагийн хуванцар бараа бүтээгдэхүүн нийлүүлэх
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: МИАТ/201901002

МИАТ ТӨХК эрх бүхий тендер оролцогчдоос Зорчигчийн үйлчилгээний нэг удаагийн хуванцар бараа бүтээгдэхүүн нийлүүлэх тухай 2 багц бүхий цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь **50,000 төгрөг**, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендер оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жилийн буюу 2017, 2018 оны нийт борлуулалт тендер санал болгож буй үнийн дүнгээс багагүй байх,

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Тендер санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байх,

Сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: Тендер санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй байх,

Тендерийн хамт багц 1-д **11,520,000 төгрөгийн**, багц 2-т **2,409,000 төгрөгийн** дүнтэй тендерийн баталгаа тус тус ирүүлнэ.

Цахим тендер оролцогч цахим баталгаа гаргах эрх бүхий арилжааны банкаар тендерийн нэг баталгаа гаргаж болох бөгөөд багц тус бүрийн баталгааны дүнг тодорхой бичсэн байх шаардлагатай.

Тендерийг **2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 10.30 цаг-аас өмнө** цахим худалдан авах ажиллагааны систем /www.tender.gov.mn /-д өөрийн аж ахуйн нэгжийн цахим гарын үсэг /PKI/-ээр нэвтрэн орж PDF 1 файлаар цахим хэлбэрт шилжүүлэн ирүүлэх ба тендерийг **2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 11.00 цаг**-т нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй.

Дотоодны давуу эрх **тооцохгүй.**

Сонирхсон этгээд тендерийн мэдээллийг доорх хаягаар авч болно.

МИАТ ТӨХК

Хан-Уул дүүрэг, 10-р хороо, Буянт-Ухаа 45,
МИАТ ТӨХК-ийн төв байр
Хангамж, үйлчилгээний хэлтэс 103 тоот
Утас: 70049860, факс: 70049919

Эдийн засаг

БАЙР СУУРЬ

Үйлчилгээндээ баримталж буй хамгийн гол зарчим бол “Харилцагчаа таньж мэдэх”

Б.Мөнх
ЗГМ

Гадаад мөнгөн гуйвуулгатай холбоотой зарим асуудлаар Монголын банкны холбооны Комплайнсын мэргэжлийн зөвлөлийн дарга А.Дэлгэрсайхантай ярилцлаа. Сүүлийн үед Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор банкуудын гадаад төлбөр тооцоо, ам.долларын клирингд хүндрэл үүсэх болсон. Нөгвөтэйгүүр Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны үнэлгээ доогуур гарсан тул Америкийн банкууд Монголын банкуудтай төлбөр, тооцоо хийхдээ өндөр шаардлага тавьж эхэлсэн билээ.

-Монголын арилжааны



Харилцагчаа таньж мэдэх нь данс нээх, гүйлгээ хийх, үйлчилгээ үзүүлэхийн өмнө хэнд, ямар үйлчилгээг үзүүлж байгаа вэ гэдэгтэй бүрэн дүүрэн хариулттай, итгэлтэй байхыг хэлж байгаа юм.

хуульд нийцүүлэн өөрчлөх шаардлага нэн тэргүүнд тулгарсан. Дараа нь харилцагчдаа тавих шаардлага шинэчлэн тодорхойлсон. Харилцагчид ч эдгээр шаардлагуудыг эерэгээр хүлээн авч, банкуудтайгаа хамтран ажиллаж байгаа нь давуу тал юм. Өнөөдөр банк, санхүүгийн байгууллагуудын үйлчилгээндээ баримталж буй хамгийн гол зарчим бол “Харилцагчаа таньж мэдэх” зарчим болсон. Харилцагчаа таньж мэдэх нь данс нээх, гүйлгээ хийх, үйлчилгээ үзүүлэхийн өмнө хэнд, ямар үйлчилгээг үзүүлж байгаа вэ гэдэгтэй бүрэн дүүрэн хариулттай, итгэлтэй байхыг хэлж байгаа юм. Мөн шаардлагатай мэдээ мэдээлэл, баримтыг харилцагчаас авах, сайн програм хангамж нэвтрүүлэх, оновчтой хяналт хийх, ажилтнуудаа сургаж мэргэшүүлэх тал дээр арилжааны банкууд илүүтэй төвлөрч ажиллаж байна.

-Тэгэхээр харилцагч нарт зөв ойлголт өгөх нь чухал байх. Энэ талаар хийгдэж байгаа ямар ажлууд байна?

-Төлөвлөсөн ажлууд эхнээсээ хийгдэж байна. Хамгийн сүүлд гэхэд Монголын банкны холбооны дэргэдэх Комплайнсын мэргэжлийн зөвлөлөөс

ЗГМ ТОВЧХОН

» **БАНК, САНХҮҮ**

29

Хувь. Банкны салбараас энэ оны нэгдүгээр сард шинээр олгосон зээлийн 29 хувь буюу хамгийн их хэмжээний зээлийг худалдааны салбарт олгосон байна. Харин гурван хувийг уул уурхай, 4.2 хувийг барилгын компаниудад олгожээ.

» **УУЛ УУРХАЙ**

13.35

Тэрбум төгрөг. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр төсвийн хөрөнгөөр үргэлжлүүлэх 39 төсөл, шинээр 17 төсөл байна. Нийт төслийг санхүүжүүлэхээр өнгөрсөн онд 13.3 тэрбум төгрөг батлагдсанаас 13.35 тэрбум төгрөгийн ажил гүйцэтгэжээ.

» **АРИЛЖАА**

Монголын хөрөнгийн бирж мягмар гарагийн үнэт цаасны арилжаагаар 27 компанийн 155,003,746 төгрөгийн үнийн дүн бүхий 504,190 ширхэг хувьцаа арилжаалаа. Үүнээс долоон компанийн хувьцааны ханш өсөж, 13 компанийнх буурсан байна. Энэ өдөр “Монгол шуудан” болон “Би Ди Сек” компанийн хувьцааны ханш хамгийн өндөр өсөлттэй байв.

» **ИНДЕКС**

0.04

Хувь. Top 20 индекс 0.04 хувиар өсөж, 20800.01 нэгжид хүрснээр зах зээлийн үнэлгээ 2.4 их наяд төгрөг боллоо.

» **ХЭРЭГЛЭЭ**

Улсын хэмжээнд дунджаар ердийн хэрэглээний 39 хоногийн шатахууны нөөцтэй байна.

» **ФОРУМ**

“Монголын геологи, хайгуул 2019” чуулга уулзалт энэ сарын 28-30-нд 11 дэх удаагаа болно. Үндэсний геологийн алба байгуулагдсаны 80 жилийн ой энэ онд тохиож байна.

» **КОМПАНИ**

270

Сая төгрөг. Монголын үнэт цаасны бирж энэ он гарснаас хойш нийт 270 орчим сая төгрөгийн арилжаа хийлээ. Үүнээс 50 сая төгрөг нь “Парк таун” бондын арилжаа, үлдсэн 220 орчим сая төгрөг нь “Анд энерги” компанийн хувьцааны арилжаа юм. “Анд энерги” компанийн хувьцааны арилжааны идэвх хоёрдугаар сар гарсаар эрс буурч, сүүлийн сар хагасын хугацаанд ердөө таван удаа арилжаад байна.

ВАЛЮТЫН ХАНШ

АНУ-ын доллар	2,631.91
Евро	2,986.56
Японы иен	23.65
ОХУ-ын рубль	40.94
БНХАУ-ын юань	391.82
БНСУ-ын вон	2.33

Сөрөг мэдээллүүд мөнгөн гуйвуулгад хүндрэл үүсгэж байна

банкууд гадаад мөнгөн гуйвуулга хийхэд багагүй бэрхшээлтэй тулгарч байна. Гадаадын банкууд хамтын ажиллагаа болон корреспондент харилцаандаа эргэлзж байгаагаа илэрхийлэх, зарим нь магадгүй харилцаагаа таслах тохиолдол гарсан. Үүний шалтгаан нь юутай холбоотой вэ?

-Хэд хэдэн шалтгаан байгаагийн хамгийн эхний нь Монгол Улсын талаар гадаад ертөнцөд тархсан янз бүрийн сөрөг мэдээллүүд, түүнтэй холбоотойгоор олон улсын байгууллагуудын гаргасан үнэлгээ гол шалтгаан нь болж байна. Жишээ нь, FATF-ын Ази Номхон далайн бүсийн байгууллага /AP-G/-аас Монгол Улсад хийсэн үндэсний эрсдэлийн үнэлгээ, “Транспаренси интернэшнл” байгууллагын гаргасан Монгол Улсын авлигын индексийн талаарх үзүүлэлтүүд байна. Мөн үүнээс гадна Европын холбооны татварын хар жагсаалт, Монголын төрийн өндөр албан тушаалтнуудын оффшор дансны

талаар “Панамын баримт”-аар нийтэд дэлгэгдсэн.

-Эдгээр баримт, мэдээлэл, үнэлгээтэй холбоотойгоор гадаадын банкуудын Монголын банкуудтай харилцах харилцаанд асуудал тулгарлаа гэж хэлж болох уу?

-Тэгж хэлж болно. Хамгийн наад захын жишээ бол Монголын банкуудын гадаадын банкинд байршиж байгаа ностро дансыг 2012 оноос эхлэн хааж эхэлснийг та бүхэн санаж байгаа байх. HSBC, Credit Suisse, Citi, Deutsche зэрэг дэлхийн томоохон банкууд Монголын зах зээлээс гарч, дансаа хаасан. Хамгийн сүүлд өнгөрсөн оны сүүлээр “Стандарт Чартеред” банк (SCB) дансаа хаасан.

-Харилцаа нь хэвийн үргэлжилж байгаа гадаадын банкууд байгаа байх. Тэдний хувьд шаардлага, нөхцөлд нь өөрчлөлт орж байна уу?

-Тийм ээ. Шаардлага, дүрэм журам нь илүү хатуу болсон. Тухайлбал гадаад шилжүүлэг, төлбөрийг зогсоож, мэдээллийг нарийвчлан шалгах, нэмэлт тодруулга хийх, холбоотой

баримт материалыг нэмж гаргуулах нь ихэссэн. Нөгөө талаас тухайн харилцагч болон гүйлгээний мэдээлэл, утга зориулалт нь төлбөр дамжуулагч, эсвэл төлбөр хүлээн авагч банкны дотоод боллого, дүрэм журамд нийцэхгүй байх тохиолдолд төлбөрийг дамжуулах, хүлээн авахаас татгалзан цуцлах, буцаах, хураах хүртэл арга хэмжээ авч байна.

-Тодруулбал, аль улсуудтай харилцахад илүү хүндрэлтэй, бэрхшээл тулгарч байна вэ?

-Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага /FATF/- аас жил бүр мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналтын тогтолцоо хангалтгүй, эсвэл ахиц дэвшил гаргаж байгаа хэдий ч тус байгууллагын эрчимжүүлсэн хяналтад байгаа улс орнуудыг зарладаг. Мөн НҮБ, Европын холбоо болон АНУ-ын Засгийн газраас мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсгийн үйлдвэрлэлтэй тэмцэх хүрээнд тодорхой улс орнууд, иргэд, байгууллагын эсрэг санхүүгийн болон бусад

төрлийн хориг арга хэмжээг авч олон нийтэд нээлттэй мэдээлдэг.

Хамгийн сүүлд өнгөрсөн оны сүүлээр “Стандарт Чартеред” банк (SCB) дансаа хаасан

Тэгэхээр эдгээр жагсаалт, хориг арга хэмжээнд хамаарах улс орнууд руу хийх болон дамжуулах гүйлгээ гадаадын банкуудын зүгээс нарийвчлан шалгах, нэмэлт тодруулга, баримт мэдээлэл гаргуулж авах зэрэг арга хэмжээ авдаг. Ийнхүү нарийвчлан шалгахдаа гүйлгээг түр зогсоож, нарийвчлан хянадаг.

-Монголын арилжааны банкуудын хувьд энэ нөхцөл байдалд яаж ажиллаж байна, ямар байдлаар зохицуулалт хийж, арга хэмжээ авч байгаа вэ?

-Бид дотоод дүрэм, журмаа

Монголбанк болон Санхүүгийн мэдээллийн албатай хамтран арилжааны банкуудын харилцагчдад зориулан “Ам.долларын гадаад гуйвуулга, олон улсын зохицуулагч байгууллагуудын шаардлага” сэдэвт уулзалт зөвлөгөөн хийлээ. Харилцагчид ч идэвхтэй оролцож, олон улсын байгууллагуудын дүрэм журам, зөвлөмжийн талаар илүү тодорхой мэдлэгтэй болж, гадаад шилжүүлэг хийхэд тулгарч буй хүндрэл бэрхшээлээ энэ үеэр хоорондоо дэлгэрэнгүй ярилцлаа.

Үндсэндээ энэ арга хэмжээ нь харилцагч нарт зөв ойлголт өгөх, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилготой байсан. Энэ зорилгодоо ч хүрсэн гэж бид үзэж байгаа. Зөвхөн энэ уулзалт форум гэлтгүй, банкууд өөрсдөө тус бүртээ, өдөр тутамдаа гадаад төлбөр тооцоонд үүсч болзошгүй эрсдэлийн талаар харилцагчдаа мэдээлэл, зөвлөгөө өгөх, олон улсын байгууллагуудын дүрэм журмыг танилцуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд онцгой анхаарал тавьж ажиллаж байна. [ЗГМ]

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

“Эрдэнэс Тавантолгой”-г хаалттай хувьцаат компаниар бүртгэлээ

Б.Тогтох
ЗГМ

Санхүүгийн зохицуулах хороо “Эрдэнэс-Тавантолгой” компанийг хаалттай хувьцаат компаниар бүртгэж, хувьцааг хадгаламжид бүртгэн авахыг Үнэт

цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд зөвшөөрлөө. Хувьцаат компани болон үнэт цаасыг бүртгэж буйтай холбогдуулан хорооноос компанийн хувьцаа эзэмшигчдийн 2018 оны ээлжит бус хурал, Төлөөлөн удирдах зөвлөлийг сонгосон шийдвэртэй холбоотой маргаантай асуудлууд,

иргэд, төрийн бус байгууллагаас гаргасан гомдлыг нэн даруй шийдвэрлэхийг “Эрдэнэс-Тавантолгой” хувьцаат компанид үүрэг болголоо.

Тус компани энэ оны эхний хагаст багтаж олон улсын хөрөнгийн зах зээлд гарахаар төлөвлөж буй. Ингэснээр нийт

гурван орчим тэрбум ам.доллар татан төвлөрүүлэхээр бэлтгэл ажлаа хангаж эхэлсэн. Хэдий тийм боловч тус компанийн 2019 оны төсөв хэт үрэлгэн болохыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс анхааруулж, төсвөө эргэн харах чиглэлийг “Эрдэнэс Тавантолгой”-д өгсөн

байна. Тухайлбал, компани энэ онд компьютер, түүний дагалдах хэрэгсэл авахад 4.5 тэрбум төгрөг төсөвлөжээ. Мөн автомашин авахад 3.5 тэрбум хуваарилжээ. Үүнээс гадна компанийн удирдлагын зардалд 21.6 тэрбум төгрөг төсөвлөсөн нь нийгэмд маргаан дагуулаад байна. [ЗГМ]

ТӨСӨВ

Гаалийн байгууллага ₮545.6 тэрбумыг төсөвт төвлөрүүлжээ

Б.Тулгат
ЗГМ

Гаалийн байгууллага энэ он гарснаас хойш гуравдугаар сарын 18-ныг хүртэл буюу ажлын 50 хоногт 545.6 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна. Өөрөөр хэлбэл, өдөрт дунджаар 10.8 тэрбум төгрөг төвлөрүүлжээ. Тухайлбал, зөвхөн гуравдугаар сард 122.8 тэрбум төгрөг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Орлого ийнхүү өсөхөд валютын ханшийн зөрүү тодорхой

хэмжээнд нөлөөлжээ. Тодруулбал, өнгөрсөн оны гуравдугаар сард төгрөгтэй харьцах ам.долларын ханш 2,395.4 байсан бол энэ жил 2,631 төгрөг буюу 235.6 төгрөгийн зөрүүтэй байгаа юм. Мөн өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад татвартай импортын барааны орлого энэ онд 129 хувиар өссөн байна. Ажлын 50 хоногийн нийт орлогыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 130.3 тэрбум төгрөг буюу 131.4 хувиар өсжээ. Үүнээс татварын орлого 52.5 хувь, хураамжийн орлого 41.5 хувийг эзэлсэн байна. [ЗГМ]

УУЛ УУРХАЙ

Prophecy Development компани “Улаан овоо”-гийн уурхайгаас дахин нүүрс олборлож эхэллээ

Т.Элиса
Шинжээч

Жилд хоёр сая тонн нүүрс гаргах хүчин чадалтай “Улаан овоо”-гийн ордны олборлолтоо гуравдугаар сард эхлүүлсэн компани мэдээллээ. Нүүрсний олборлолт, борлуулалтын хэмжээ нь 21 мянган тонн байгаа бөгөөд энэхүү ордын нүүрсийг худалдаж авах сонирхлоо дотоод, гадаадын компаниуд илэрхийлээд байгаа аж.

Prophecy Development компани “Улаан овоо”-гийн уурхайгаа Монголын компанид түрээслүүлэх гэрээг гурван жилийн хугацаатай байгуулснаа өнгөрсөн оны аравдугаар сард зарласан юм.

Тус компани “Улаан овоо”-гийн үйл ажиллагаатай холбоотой бүхий л хөрөнгө оруулалт, зардал, татвар, роялтиг төлөх үүрэг хүлээсэн байна. Мөн эндээс олборлосон нэг тонн нүүрс тутмын хоёр ам.долларыг Prophecy Development-д төлөх аж. Энэхүү гэрээг байгуулснаас

хойш олборлогч компани нь “Улаан овоо” уурхайд нийт 700 мянган ам.долларын санхүүжилт хийгээд байна. “Улаан овоо” орд Сэлэнгэ аймгийн нутагт оршдог. ОХУ-тай хиллэдэг Зэлтэрийн боомтоос 17 км-ийн зайтай, Сүхбаатарын төмөр замаас 120 км-ийн зайтай байрладаг. 2012-2014 онд энэ уурхайгаас 500 мянган тонн нүүрс олборлож, “Эрдэнэт үйлдвэр”, Улаанбаатар төмөр зам, Хөтөлийн цемент шохойн үйлдвэр зэрэг Орос, Монгол нийлсэн 28 компанид худалджээ.

Эдийн засаг

ТЭРБУМТАН ТӨРҮҮЛДЭГ ЗАХ ЗЭЭЛД МОНГОЛЧУУД “ӨЛГИЙ”-ТЭЙ БАЙНА



Интернэт тоглоомын ертөнцөөс төрөх тэрбумтнуудын тоо нэмэгдсээр

Г.Байгал
@baigalZGM

Хэрэглэгчийн тоо нь 2.3 тэрбум давсан ертөнц үүсээд 20 хүрэхгүй жил болж байна. Гэхдээ шинэ зуунтай зэрэгцэн үүссэн энэ ертөнц дэлхийн бизнесийн салбарын хамгийн өсөлттэй зах зээлд тооцогдож, хөрөнгө оруулагчдыг хошууруулсаар. Монголчуудын ашиг орлого олохоосоо илүү зугаацах, алжаал тайлах хэрэгсэл болгон түүхүү ашигладаг интернэт тоглоомын ертөнцөөс дэлхийн бизнест цахиур хагалсан шинэ тэрбумтнууд төрсөөр байна.

Зэр эвсэг хайж, амьд үлдэхийн төлөө тэмцдэг Free Fire тоглоомыг хөгжүүлэгч Sea компанийн хувь эзэмшигч, Хятад гаралтай Форрест Ли 41 насандаа дэлхийн тэргүүн баячуудын эгнээнд бичигдэж эхэлснийг Bloomberg хэдхэн хоногийн өмнө мэдээллээ. Тус компанийн бүтээсэн виртуал ертөнцөд элсэгчдийн тоо АНУ-ын хүн амыг хэдийн давжээ. Форрест Ли Сингапурт төвтэй Sea компанийн хувьцааны 13.8 хувь буюу нэг тэрбум орчим ам.долларын хөрөнгө эзэмшиж байна. Эхний тэрбумтан нь Форрест Ли биш юм. Тулаачдын тэмцлийг өгүүлэх Fortnite тоглоомыг бүтээсэн, тэрбумтан Тим Суини мөн энэ тоглоомоос мэндэлсэн түүхтэй.

Ийнхүү гарт үл баригдах хийсвэр ертөнц дэлхийн нийтийг соронз мэт татаж, чиглэх хөрөнгө, санхүүгийн урсгал ч үржихийн хүрдээ хурдтай



өсөж байна. Ухаалаг төхөөрөмжөөс хэт хамаатай болсон орчин цагийн дэлхийд видео тоглоомын байлдан дагуулалт үргэлжилсээр байна.

ТЕХНОЛОГИЙН МАНЛАЙЛАГЧИД ТОГЛООМ РУУ ХОШУУРАВ

Хэрэв та үргэлж биш юмаа гэхэд үе үе гар утсаараа тоглоом тоглож цаг нөхцөөх эсвэл тархиа амраадаг бол аль хэдийн энэ ертөнцийн нэг гишүүн болсон гэсэн үг. Ер нь дэлхийн хаана л бол хаана утаснаас уяатай байдаг хэрэглэгчид тоглоомын зах зээлийг тэлж, хөрөнгө оруулалт, хөгжигсдийн тоо нь нэмэгдэх гол шалтгаан болоод байна. Интернэт тоглоом нийт орлогынхоо талаас илүүг нь зөвхөн хөдөлгөөнт утаснаас олдог байна.

Newzoo-гийн мэдээлснээр энэ зах зээлийн хэмжээ 2018 оны байдлаар 137.9 тэрбум ам.долларт хүрчээ. Хүний бүтэсэн, хийсвэр хорвоо ертөнцийг чиглэх мөнгөний хэмжээ сүүлийн жилүүдэд тасралтгүй нэмэгдэж буй бөгөөд ирээдүйд ч өсөлтөө хадгалах өөдрөг таамгийг шинжээчид танилцуулж байгаа юм. 2021 онд гэхэд нийт орлого нь 180 тэрбум ам.доллар давах төлөвтэй.

Тоглоом ийнхүү ашиг олж болох “авдар” болж эхэлсэн тул технологийн компаниуд энэ салбар луу хошуурсан. Тухайлбал, БНХАУ-ын Tencent Holdings компани нийтлэлийн эхэнд өгүүлсэн хоёр тэрбумтны компанид хувь эзэмшигч. Зөвхөн Tencent Holdings гэлтгүй бидний сайн мэдэх Microsoft, Apple, Sony зэрэг технологийн манлайлагчид тоглоомын ертөнцийн гол тоглогчид юм. Алдарт Apple л гэхэд хамгийн ашиг хүртдэг компаниудын нэгд тооцогддог бөгөөд өөрийн программ хангамжийн онлайн дэлгүүр буюу App store-оор дамжуулан, энэ төрлийн тоглоом борлуулж байна. Үүнээс гадна монгол залуусын түгээмэл тоглодог World of Warcraft -ийг



бүтээгч Activision Blizzard-ийн зах зээлийн үнэлгээ 29.93 тэрбумаар хэмжигдэж байна. Ер нь эдгээр компани тоглоом сонирхогчдыг тоглохоос өөр аргагүй болтол нь сонирхол, хүслийг нь төрүүлээд зогсохгүй мөнгөн урсгалыг ч соронз шиг татдаг байна

ӨСӨЛТИЙН ИРЭЭДҮЙ-ЭНЭТХЭГ, БНХАУ

Энэ зах зээл рүү урсаж буй гурван ам.доллар тутмын нэг нь Хятадын зах зээлийнх аж. Хүн амын тоогоор тэргүүлэгч энэ гүрэн дэлхийн интернэт тоглоомын зах зээлийн өлгий нутагт тооцогдох боллоо. Үүнээс гадна сүүлийн жилүүдэд хамгийн ирээдүйтэй зах зээлээр Энэтхэг улс нэрлэгдэж байна. Энэтхэгийн интернэт тоглоомын зах зээл хурдтай өсөж, үүнийг нь ч соргогоор анхаарсан Хятадын Alibaba, Tencent зэрэг компани тус улсад үүрээ засаж эхэлжээ. Уг нь БНХАУ, Энэтхэг улс бол монголчуудад хамгийн ойр зах зээл. Мөнгө буцалж буй энэ зах зээлийн хамгийн эрэлтгүй бүс нутаг, улс орнуудтай Монгол Улс улс төр, эдийн засаг, хүн хоорондын нягт харилцаатай оршин тогтнож байна гэсэн үг.

Ингээд бодохоор дэлхийн том компаниуд хүртэл хошуурч буй энэ бизнест монголчууд зөвхөн хэрэглэгчийн байр сууринаас оролцох бус орлого олох боломж байсаар байна. Сүүлийн жилүүдэд манай технологийн салбарын залуус хамтран энэ төрлийн гарааны бизнесүүдийг хөгжүүлж буй ч өнөө хэр олон улсын түвшинд өрсөлдөхүйц тоглоом бүтээсэн нь тун ховор. Гэхдээ хэд хэдэн компани олон улсад бүтээгдэхүүнээ нэвтрүүлжээ. Тухайлбал, монгол залуусын Nomadic Bear Games компани сүүлийн таван орчим жил тогтвортой үйл ажиллагаа явуулж байна. Өнгөрсөн онд дэлхийн зах зээлд хоёр ч бүтээгдэхүүнээ амжилттай нэвтрүүлсэн компанийн нэгэн тоглоомыг олон улсын хэрэглэгчид

12 сая удаа татжээ.

Тус компани тоглоомын зах зээл дэх гар утсанд суурилсан, Hyper Casual буюу хэцүү биш хэдий ч тоглоход таатай мэдрэмж төрүүлдэг төрлийн тоглоом бүтээгч аж. Ингэхдээ өөрсдийн үзэл санааг шингээж, дэлхийн дийлэнх хэрэгчдийн сонирхолд нийцүүлэхийг зорьдог байна. Дэлхийн маш олон залуустай бид өрсөлддөг ч монгол хүний ур ухаан, сэтгэлгээний чадвараараа бусдаас ялгарахыг зорьдог хэмээн компанийн үүсгэн байгуулагч Х.Хангай ярилаа.

Ер нь манай тоглоом бүтээгчдийн дийлэнх нь сонирхогчийн шинж чанартай, бор зурхээрээ энэ салбарт ажиллаж байна. Тиймээс Монголын тоглоом сонирхогчдын дунд Mongolian Game Developers Contest тэмцээн энэ өдрүүдэд болж байна. Одоогоор нэгдүгээр шат нь үргэлжилж буй бөгөөд 54 багийн 167 оролцогч бүртгүүлж, 19 бүтээл ирүүлжээ.

Басхүү Монгол Улс интернэт тоглоомын салбарын хэрэглэгчдийн хувьд дэлхийгээс нэг их хошоргүй, зэрэгцэн алхаж байгаа гэхэд болно. Цаашлаад энэ төрлийн тоглоомд хүүхэд залуус донтох, зүй бусаар ашиглах зэрэг сүүдэртэй талууд ч түгээмэл болж буй. Харин тоглоом бүтээх, бий болгох, орлого олж, ашиг хүртэхдээ монголчууд хоцорч, унхиагүй байсаар.

Уг нь хил хязгаар гэж үгүй энэ салбар Монгол шиг далайд гарцгүй, жижиг зах зээлтэй улсад орлого олж болох талбар. Дээрээс нь дэлхий дахинд энэ төрлийн тоглоом нь зөвхөн арилжаа, сурталчилгаанаас орлого олоод зогсохгүй тоглоомын дүрүүдийнх нэр, хувцас, хэрэглэл нь чамлахааргүй мөнгө авчирдаг байна. Гэхдээ Монгол Улс өнөө хэр энэ хорхой хүргэм зах зээлд олон улстай өрсөлдөхөд бэлэн биш, “өлгий”-гэй хэвээр байна. [31W]

ЗАХ ЗЭЭЛИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ:

